

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМ, ХҮРЭН ТОЛГОЙ УУРХАЙН  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-005459/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2697947/

**ХЯНАСАН:**

“ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР”-ЫН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН...../ /

**БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:**

“ХҮРЭН ТОЛГОЙ КОАЛ МАЙНИНГ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ.....И.НАЯНТАЙ  
“ХҮРЭН ТОЛГОЙ КОАЛ МАЙНИНГ” ХХК-ИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ИНЖЕНЕР.....П.ЭНХБАЯР



## ГАРЧИГ

ОРШИЛ.....	1
Тайлангийн зорилго.....	1
Товч танилцуулга.....	1
ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
Түүхэн товчоон.....	2
Газар нутгийн онцлог.....	2
Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд.....	2
Физик газарзүй, байгаль цаг уурын нөхцөл.....	3
Цаг агаарын төлөв байдал, олон жилийн төлөв.....	3
ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	4
Гадаргын болон газрын доорхи ус.....	4
Хөрс.....	4
Ургамалжилт.....	4
Биологийн төрөл зүйл.....	4
Амьтны аймаг.....	6
ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	7
Байгаль орчны бодлого.....	7
1. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	8
Ажиллах горим, ажлын цаг.....	9
Ажлын байр.....	9
Нийгмийн хариуцлага.....	9
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	10
Агаарын чанар.....	10
Хөрсөн бүрхэвч.....	11
Гадаргын ба газрын доорхи усны нөөц.....	11
Болзошгүй аюул ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд.....	12
Ургамал ба амьтанд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	11
БО-ны төлөвлөгөө болон БОНБНҮ-д тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбогдсон арга хэмжээнүүд.....	14
Төсөв зохион байгуулалт.....	15
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	31
Төсөв зохион байгуулалт.....	35
Техникийн нөхөн сэргээлт.....	37
Биологийн нөхөн сэргээлт.....	38

4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	56
Төсөв зохион байгуулалт.....	56
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	75
6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	75
Төсөв зохион байгуулалт.....	76
7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	77
Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах, бууруулах.....	79
8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	88
Төсөв зохион байгуулалт.....	90
Ахуйн хог хаягдал.....	92
Үйлдвэрийн хог хаягдал.....	95
Аюултай хог хаягдал.....	95
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	97
Төсөв зохион байгуулалт.....	98
Агаарын чанар.....	100
Гадаргын болон газрын доорхи ус.....	100
Хөрсөн бүрхэвч.....	101
Ариутгал.....	102
Амьтны аймаг.....	103
10. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ.....	104
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	105
Төсөв зохион байгуулалт.....	106
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	107
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө биелэлтийн нийт зардал.....	109
ДҮГНЭЛТ.....	110

## ОРШИЛ ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО

“Хүрэн толгой коал майнинг” ХХК нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт “Нарийн сухайт”-ын нүүрсний орд газарт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа болон Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэлийг хүлээн авсан ажлын хэсгийн дүгнэлт, Өмнөговь аймгийн “Байгаль орчин аялал жуулчлалын газар”-аас гаргасан албан даалгавар зэргийг Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд байгаль орчны менежментийн төлөвлөгөө, уулын ажлын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөртөө уялдуулан байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

### *Товч танилцуулга*


Манай компани нь анх Монгол улсын хуулийн этгээд “МОНГОЛЫН АЛТ” ХХК, БНХАУ-ын ӨМӨЗО-ны “ЧИН ХУА” группийн 50:50 хувийн хөрөнгө оруулалттайгаар 2002 оны 09-р сарын 04-нд анх үүсгэн байгуулагдсан.

2003 оны 04-р сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 19 дахь жилдээ ажиллаж байна. Нарийн сухайтын орд газарт “Гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан компани”-ийн статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаад 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн а/02-19 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор БНХАУ-ын хуулийн этгээд “Чин Хуа” корпорацийн эзэмшлийн 50% хувьцааг МОНГОЛЫН АЛТ КОРПОРАЦИД, шилжүүлэн авч, 100% үндэсний компани болж, компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд өөрчлөлт орсон.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд өөрчлөлт орж, үндэсний компани болсонтой холбоотойгоор компанийн оноосон нэр болох “Чинхуа-МАК Нарийн сухайт” ХХК-ийг “Хүрэн толгой коал майнинг” ХХК болгон өөрчилж, 2020 оны 08 дугаар сарын 04-ний өдөр Хуулийн этгээдийн Улсын бүртгэлд албан ёсоор бүргүүлсэн.

### *Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг, захиргааны харьяалал*

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Урт багийн нутагт Улаанбаатар хотоос ургаш 849 км, Даланзадгад хотоос баруун тийш 296 км, Гурвантэс сумаас зүүн ургаш 34 км, Шивээхүрэн боомтоос 56 км зайд Хүрэн толгой хэмээх газарт явагдаж байна.



Хүрэнтолгойн уурхайн байршил

## **ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

### ***Түүхэн товчоон***

Гурвантэс сум нь 1954 онд анх Тост нэртэйгээр одоогийн Сэврэй сумын 1 дүгээр баг, Ноён сумын 3, 4, 5 дугаар багууд нийлж Улаан толгой гэдэг газар 281 өрх, 943 хүн амтай, 63,2 мянган малтай байгуулагджээ. 1959 онд орон даяар нэгдэлжих хөдөлгөөн ялсаны үрээр, 1960 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Гурвантэс сум гэж нэрлэгдэн, одоогийн байрлаж байгаа Уртын дэнжид төвлөрсөн байна.

### ***Газар нутгийн онцлог***

Тус сум нь 2.9 сая га газар нутагтай хойт, баруун, баруун урд талаараа Баянхонгор аймгийн Шинэ жинст, Баянговь, Баянлиг, зүүн, зүүн хойт талаараа өөрийн аймгийн Сэврэй, Ноён, урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эзний хошуутай хиллэж, Говь-Алтайн нурууны цаад цөлөрхөг бүсэд оршдог. Улаанбаатараас 870 км, аймгийнхаа төвөөс 320 км алслагдсан байгалийн үзэсгэлэнт газар ихтэй, цаашид аялал жуулчлал хөгжих бүрэн боломжтой газар нутагтай.

Сумын газар нутгийн ихэнх хэсэг нь олон сая жилийн өмнө амьдарч байсан аварга үлэг гүрвэлийн орон гэгдэх бөгөөд ховор нандин олдвороороо гадаад дотоодын эрдэмтдийн анхаарлыг татаж Зөвлөлт, Польш, Монголын палеонтологичид хайгуул шинжилгээ хийж тэдний ажил шинэ шинэ олдвороор баяжсараар ирсэн юм. Энэхүү олдворууд нь Москва, Варшав, Улаанбаатар, Даланзадгадын музейд өнө эртний аварга денозавр болон сүндэрлэж чимэг болж байна.

Мөн сайн чанарын чулуун нүүрс, давсаар баялаг, алт, төмрийн хүдэр, барилгын сайн чанарын шохой, шохойн чулуу, төрөл бүрийн өнгийн шороон будаг болон гартаам, мана зэрэг үнэт чулуу элбэг тохиолдоно.

### ***Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд***

Гурвантэс сум нь засаг захиргааны анхан шатны нэгж болох 5 багтай, эдийн засгийн гол суурь баазаа мал аж ахуйг болгон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх эхлэлийг тавин ажиллаж байна. Тус сум нь 2018 оны байдлаар 4934 хүн амтай 187458 толгой малтай 1558 өрхтэй. Сумын төвд төсөвт 7 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна холбооны салбар, банк, цаг уур, ШТС-ийн зэрэг хувийн хэвшлийн байгууллагууд ажиллаж байна. Сумаас 55 км-т орших Дундголын давсны уурхай, нөхөрлөл нь жилдээ 220 орчим тн давс олборлож борлуулдаг ба сумаас 25 км-т орших нүүрсний орд газарт уул уурхайн компаниуд нүүрс олборлон БНХАУ-д экспортолж байна.

Гурвантэс сум нь цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, цагдаагийн тасаг ажиллаж байна. 2005-2006 оны хичээлийн жилээс 9 жилийн дунд сургууль 12 жилийн сургалттай сургууль болон өргөжсөн. Мөн тус сумын нутагт хилийн цэргийн 0166 дугаар анги байрладагаас гадна “Шивээ хүрэн”-ийн хилийн боомт үйл ажиллагаа явуулж байна.

Холбоо харилцааны хувьд 2006 оны 11 сард мобикомын үүрэн телефон суурилагдан, хүн амын 70 орчим хувь нь гар утас хэрэглэж байна. БНХАУ-ын ӨМӨЗО-рны хөрш аймгаас өндөр хүчдэлд холбогдсон, 24 цагийн гэрэл цахилгаантай.

### ***Физик газарзүй, байгаль цаг уурын нөхцөл***

Хүрэн толгойн нүүрсний ордын геологийн тогтоц Нарийнсухайтын нүүрсний орд нь Овоот хурлын грабень синклиналийн хойт жигүүрийг үүсгэж байгаа дээд палеозой-доод мезозойн терриген тунамал хурдасны дунд илэрсэн байдгийг өмнөх судлаачид тогтоосон ч сүүлийн үеийн судлаачдын ажлуудаар түүний насыг бүр мезозойны дунд үед хамааруулах хандлага ажиглагдаж байна.

Манай нэртэй эрдэмтдийн Ноён сумын хотгорт ялгасан триасын хурдасны доод талд түүнийг эмжсэн байдлаар нүүрс агуулсан хурдас илэрсэн байдгийг дээд пермийн Дэлийншанд формацид хамааруулсан байдаг юм. Иймээс бид энэ үндэслэлээр Нарийнсухайтын нүүрс агуулсан хурдасыг жиших аргад тулгуурлан дээд пермийн Дэлийншанд формацид, түүнийг хучиж байгаа хурдасыг триасын үеийн Ноён сумын формацид тус тус хамааруулж үзлээ.

Физик газарзүйн мужлалын хувьд Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн мужид хамаарна. Хойд талаараа Бумбын нуруу (2360 м), Тостын нуруу (2517 м), Тахилтын хяр (2316 м) гэсэн 30 км өргөнтэй 180 км үргэлжлэх уулсаар хүрээлэгдэн оршдог. Дээрх уулсаас эх авсан хуурай сайрууд байх ба зарим хэсэгтээ нилээд өргөн бөгөөд хэдэн арван км үргэлжилдэг бөгөөд урагш хил давтал уруу, хил давтал үргэлжилнэ.

Ордын дүүргийн хувьд харьцангуй өндөр 1525-1560 м. Төв Азийн гадагшаа урсгалгүй ай савд хамаарагдана. Тухайн жилийн цаг уур, хур тунадасны хэмжээнээс хамаарч усны горим ихээхэн хувьсамтгай бөгөөд их цас орж хайлах, үргэлжилсэн бороотой үед хэдэн арван км үргэлжлэх хуурай сайрууд түр зуурын ширүүн урсгалтай гол болж хувирах ба бороо зогсмогц урсац байхгүй болдог онцлогтой. Хагарлын гарал үүсэлтэй олон тооны булаг тохиолдох ба ихэнх нь мөн урагш урсгалтай бөгөөд элсэн доогуур шурган алга болдог. Хүн малын унданд гар хийцийн худаг хэрэглэдэг бөгөөд усны түвшин нь 1-2 м, заримдаа 5-7 метр байдаг байна.

### ***Цаг агаарын төлөв байдал, олон жилийн төлөв***

Монгол орны уур амьсгалын гол онцлог бол жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалд өргөрөгийн болон өндрийн бүслүүрийн ялгаа тодорхой илэрдэг явдал юм. Монголд богино (VI сараас VIII сарын дунд хүртэл үргэлжлэх), хуурай зун, ихээхэн хүйтэн, урт (XI сараас IV сар хүртэл үргэлжлэх) өвөлтэй, хавар намрын улирлын үргэлжлэх хугацаа жилээс жилд өргөн хүрээнд хэлбэлздэг онцлогтой. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөл  $-15-20^{\circ}\text{C}$  хүйтэн, зун  $+30+35^{\circ}\text{C}$  заримдаа  $+40^{\circ}\text{C}$  хүрч халдаг. Нэгдүгээр сарын агаарын дундаж температур  $-14-18^{\circ}\text{C}$ , ). Үнэмлэхүй их халуун нь  $+28+44.0^{\circ}\text{C}$  хүрнэ. Говь цөлийн бүсэнд 150-50 мм орчим хур тунадас унах ба хур тунадасны 85% орчим нь жилийн дулаан улиралд /IV-IX сард/ үүнээс зөвхөн 7,8 дугаар сард 50-60% нь орно.

Монгол оронд үүлшил бага, цэлмэг өдрийн тоо их, жилдээ 230-260 хоног байх тул жилдээ 2600-3300 цаг нар гийгүүлнэ. Монголын тал хээр, говь цөлийн бүс салхи ихтэй. Жилийн дундаж салхины хурд энэ бүс нутагт 4-6 м/с. Монгол орны нутгийн 41.3%-ийг эзлэх говь-цөлийн бүсэнд сул шороо элбэг, салхи ихтэй тул шороон шуурга олонтоо тохиолдоно. Энэ бүс нутагт жилдээ 30-100 өдөр, Монгол элсний өмнөд захад жилдээ 120 өдөр шороо хийснэ.

## **ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

### ***Гадаргын болон газрын доорхи ус***

Тухайн бүс нутаг хойд хэсгээрээ Тост (2517м), Хүрэн хана (2397м), Ноёны нам өндөртэй нурууд өргөргийн дагуу зурваслан тогтох бөгөөд уулсын бэлийн дагуу гадаргын харьцангуй өндөр 1600 м хүрнэ. Гадаргын өндөржилт нь урд зүгт аажим налуу үүсгэн, Нарийн сухайтын нүүрсний ордын орчим 1500 м үнэмлэхүй өндөртэй болох ба бага зэргийн талархаг гадаргуу үүсгэн бага зузаантай бэл, хормой хурдсаар хучигдаж олон тооны хуурай сайруудаар хэрчигдэн Нарийн сухайтын тохролоос урагшаа жижиг дов, толгодорхог гадаргатай нийлнэ. Ихэнх сайрууд тухайн уурхайн урд хэсгийн толгодорхог гадаргын ар бэлд тулж садарга үүсгэн сарних ба зарим томоохон сайрууд гадаргын үндсэн хэв шинжид хөндлөн чиглэлд хэрчигдэл үүсгэдэг онцлогтой. Дээр дурдсан гадаргын онцлог шинжүүдээс хамааран бүс нутгийн хэмжээнд газрын доорх усны урсац пролювийн сэвсгэр хурдсаар дамжин Овоотын бүсийн толгодорхог гадаргад тулахаас гадна өргөрөгийн дагуу орших Нарийн сухайтын тохрол, дээд пермийн Дэлийн шанд формацын нүүрс агуулагч хурдсын гарш хэсгүүдтэй давхцан газрын гадаргууд булаг хэлбэрээр илэрдэг.

### ***Хөрс***

Хөрс – газарзүйн мужлалтаар Төв Азийн Говийн их мужийн өргөрөгийн бүсчлэлийн цөлийн бор саарал хөрс бүхий 10-р тойрогт багтана. Ордын талбайд цөлийн бор саарал хөрсзонхилох боловчбулаг шанд бүхий хотгор газраар цөлөрхөг хээрийн нугат бор хөрс алаг цоог байдлаар тархсан.

### ***Ургамалжилт***

Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Нарийн сухайтын нүүрсний орд газар нь Алтайн өвөр говийн цөлийн тойрог, Алаша говийн тойрог болон Говь-Алтайн уулын цөлөрхөг хээрийн гэсэн 3 н тойрог хамаардаг учир ургамлын аймгийн хувьд дээрх тойргуудын ургамлын аймгуудын бүрдлийг агуулсан өвөрмөц онцлогтой бүс юм.

### ***Биологийн төрөл зүйл***

Уурхайн ойр орчим ургамлын аймаг, ургамалжилт

Ургамлан бүрхэвчийн тухайд цөл, цөлөрхөг хээрийн сөөг, сөөгөнцөр, заримдаг сөөг зэрэг цөлийн бүсэд дасан зохицсон монгол орны унаган ургамлууд зонхилон тархсан. Ургамалжилтийн зонхилох хэв шинж нь зүүн гарын улаан бударганат, хуурай сайрт шар хотир-монгол бүйлст- алтан харгана- улаан бударганат хэв шинжтэй байх бөгөөд өргөн хотгор, уст цэг, булгийн хужир, мараалаг, давстай чийгсэн газарт Сибирь хармаг, Гялгар дэрс, Гоолиг бадаргана, Ширэг улалж, ургасан байдаг.

*Бэрээмэг*

*Тайжийн жинс*



*Хотир*

*Улаан бударгана*



*Шар хотир*


*Хунчир*





### Амьтны аймаг

Амьтны аймгийн бүрэлдэхүүний үндсэн хэсгийг говь цөлийн бүсийн амьтад бүрдүүлэх боловч тодорхой хэсгийг нь алтайн уулархаг газрын амьтад болох Аргал, Янгир, зэрэг ховор амьтад уулархаг газраар тохиолдоно. Уурхайн орчимд саарал чоно, үнэг, хярс, туулай, зэрэг хөхтөн амьтад, мөн могой, хонин гүрвэл, олон тооны шувууд байна.



## **ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

### ***Байгаль орчны бодлого***

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьж ажилладаг.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгон ажилладаг. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгах, нөхөн сэргээлтийг стандартын шаардлагад нийцүүлэн боломжит хамгийн их хэмжээгээр хийхэд онцгойлон анхаардаг.

Манай компани байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэж, энэхүү биелэлтийн тайланг бичих.

Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, ил тод байхыг эрмэлзэн ажилладаг.


## 1. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Манай компани нь 2008-2010 онд ашиглалтын үеийн хайгуул хийж 300 м хүртлэх гүнд 28.6 сая тн нүүрсний нөөцийг нэмэгдүүлэн тогтоож 2011 оны 5 дугаар сарын 27 өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар оруулан Эрдэс Баялаг Эрчим Хүчний Сайдын 2011 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 207 тоот тушаалаар батлуулсан.



2023 онд **3.2 сая.тонн** нүүрс олборлох төлөвлөгөөтэй ажиллаж байна. 10-р сарын 25-ны байдлаар 2.0 сая.тонн нүүрс олборлож, **1.81 сая.тонн** нүүрс экспортонд гаргаад байна.

2023 онд хөрс хуулалт  $11.3$  сая/ $m^3$  хөрс хуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. 10-р сарын 25-ны байдлаар **6.8 сая/ $m^3$**  хөрс хуулаад байна. Уурхайн талбайд 4,5-12  $m^3$  шанаганы багтаамжтай НІТАСНІ-870-2ш, НІТАСНІ-1200, НІТАСНІ-1900, САТ-385С маркийн экскаватор, 100-232 тоннын даацтай өөрөө буулгагч автомашин ТЕРЕХ TR100С, САТ-793D, САТ-777D мөн ZL-50С, НАУНГУІ-852 маркын дугуйт ачигч 2ш, LW-1200 маркын дугуйт ачигч 1ш, Грейдер, 20 тн багтаамжтай усалгааны 2 машин зэрэг нийт 40 гаруй тооны уурхайн хүнд ба хөнгөн тэрэг, тоног төхөөрөмж ажиллаж байна.



## Ажиллах горим, ажлын цаг

Ээлжийн үргэлжлэх хугацаа - 11 цаг

Хоногийн ээлжийн тоо - 2

Жилд ажиллах хоног - 365

## Ажлын байр

Тус компанид нийт 178 хүн ажиллаж байна.

- Орон нутгийн - 29 хүн
- Бусад аймгийн харьяат - 149 хүн



## Нийгмийн хариуцлага

Орон нутгийн иргэдийн амьжиргаа, жижиг дунд бизнесийг дэмжих үйл ажиллагаа:

- Орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих зорилгоор хөдөлмөр хамгааллын бээлийг орон нутгийн компаниудаас авдаг
- Мөн ажиллах ажилчдын тодорхой хувийг орон нутгаас авах бодлого баримтлан ажиллаж байна.

## **2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажил нь уул-техникийн, инженерийн зураг төсөл, хөдөө аж ахуйн болон бусад төрлийн арга хэмжээнүүдээс бүрдэх бөгөөд эдгээр ажлуудын үр дүнд уулын ажлын явцад эвдэрсэн газрын биологийн үр өгөөж сэргээгдэхээс гадна байгаль орчны төлөв байдал сайжрах ёстой. Уурхайн эвдэрсэн газарт уул-техникийн нөхөн сэргээлт хийж, техникийн нөхөн сэргээлтээр овоолго болон ухшуудыг хэлбэршүүлэн тэгшилж биологийн нөхөн сэргээлтийн ажлыг бүс нутгийн хөрс, ус, агаар мандал, цаг агаар болон уур амьсгал зэргээс хамааруулан ургамалжуулах ажлыг зөв зохистойгоор шат дараалалтайгаар зохион байгуулах шаардлагатай. Биологийн нөхөн сэргээлтийн ажилд шаардлагатай ургамал нь халуун хүйтний улиралд тэсвэртэй тухайн бүс нутагт ургадаг ургамлын төрлийг тарих, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг салхины нөлөөнөөс хамгаалах зорилгоор модлог ургамал тарих ёстой. Хүрээлэн буй орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах улмаар хүмүүсийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах асуудалтай холбогдон уурхайн олборлолтын үйл ажиллагааны дүнд үүсэх өөрчлөгдөж эвдэрсэн газрыг нөхөн сэргээх технологийг боловсруулан эрчимтэйгээр үйлдвэрлэлд нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Стандарт, нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- MNS 5850:2008, Эвдэрсэн газарт хучилт хийх хөрсний стандарт, техникийн шаардлага.
- MNS 5916:2008, “Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт
- MNS 5917:2008, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага.
- MNS 5918:2008, Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага.

### ***Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл***

Төслийн үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлт, өрөмдлөг, тэсэлгээ, ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болож байгаа юм. Мөн хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй ихсэх шинж чанартай байна.

Тоосны эх үүсвэрт дараах зүйлс орно:

- Үржил шимт хөрс хуулахад үүсэх тоос,
- Үржил шимт хөрсийг ачих, буулгахад үүсэх тоос,
- Зам барилгын ажлын үед үүсэх тоос,
- Хөрс чулуулгийг хуулахад үүсэх тоос,
- Уулын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоос,
- Бусад үйл ажиллагааны явцад эвдэгдсэн газраас үүсэх тоос.

Тоос нь нүдэнд үл үзэгдэхээс үзэгдэх, усанд үл нордоогоос нордог хүртэлх хэмжээтэй хөрс, шорооны нийлмэл шинж чанартай байна. Төслийн талбай болон түүний ойр орчимд тархах магадлалтай. Тоосжилт өндөртэй ажлын байранд байгаа хүмүүс, ойролцоо нутаглах иргэд, ургамлын бүрхэвч хамгийн ихээр өртөх магадлалтай.

### ***Хөрсний эвдрэл, элэгдэл***

Төслийн үйл ажиллагааны явцад барилга байгууламжийн суурь бэлдэх, зам барих, суваг шуудуу ухах, шугам хоолой татах, хаягдлын далан байгуулах, ил уурхайн бэлтгэл ажилд үлэмж их хэмжээний газар эвдрэлд орж байгалийн унаган төрхөө алдана. Хөрс хуулалт болон төслийн үйл ажиллагааны явцад хөрс эвдрэлд орохын зэрэгцээ үржил шимээ алдах сөрөг нөлөөлөл байна. Уурхайн эдэлбэр газар болон түүнээс гаднах дэд бүтцийн зарим талбай өртөх магадлалтай. Тухайн газрын хөрс, ургамал, амьтан өртөнө. Ил уурхайн бүтээн байгуулалтын ажил эхэлснээр үржил шимт хөрс хуулалт хийгдэж, газрын хэвлийд хонхор үүсэн гүнээс гарах их хэмжээний хаягдал чулуулгийн овоолго газрын хэвлий дээр бий болон газрын ландшафтанд өөрчлөлт бий болно.

### ***Усан орчинд үзүүлэх нөлөөлөл***

Ажилчдын унд ахуйн усны хэрэгцээг цэвэршүүлсэн усаар хангаж байна. Мөн цэвэршүүлсэн бохир усыг дахин ашиглаж болох эсхийг төрийн байгууллагуудтай хамтран туршилт, судалгааны ажлыг судлах юм.

### ***Ургамал ба амьтанд үзүүлэх сөрөг нөлөөлөл***

Хөрс хуулалтаас үүдэн тухайн талбайн ургамлан нөмрөг устаж үгүй болно. Мөн тус газарт нутагшсан амьтад амьдрах орчноо алдана. Уурхайн үйл ажиллагаа ялангуяа хөрс хуулалтаас шалтгаалан янз бүрийн талбайн ургамлын бүрхэвч өртөнө. Ургамлан нөмрөг устсанаас тухайн орчны агаарт өөрчлөлт орж, хуурайшилт бий болно. Уурхайн эдэлбэр газар, дэд бүтцийн зарим талбайн ургамал, амьтан өртөх магадлалтай.

### ***Хог хаягдлын нөлөөлөл***

Төслийн барилгын ажлын явцад ажилчдын нийтийн байр, хоолны газар, ажлын байр, засвар үйлчилгээний хэсэг, агуулах зэрэг бүх ажлын байрнуудаас хатуу шингэн хог хаягдал гарна.

- Хатуу хог хаягдал: Ахуйн хог хаягдал, хаягдал мод, төмөр, хуучин дугуй, сэлбэг
- Шингэн хаягдал: Ахуйн бохир ус, ашигласан тос, түлш шатахууны хаягдал

Хатуу шингэн хог хаягдал нь орчны хөрсийг, гүний усыг бохирдуулах боломжтой. Тухайн газрын хөрс, ургамал, амьтан нөлөөлөлд хамгийн түрүүнд өртөх магадлалтай.

### ***Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүсэх байгаль орчны зөрчил***

Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад төрөл бүрийн осол гарч болзошгүй байдаг. Энэ нь үйлдвэрийн барилга болон инженерийн бусад байгууламжийг барьж байгуулах газрыг сонгох, зураг төсөл хийх, тоног төхөөрөмжийг суурилуулах, угсрах, тоног төхөөрөмжүүдтэй харьцаж ажиллах зэрэг бүхий л үйл ажиллагаатай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, ажилчид, инженер, техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчих, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны хяналт суларснаас элдэв осол гарч, байгаль орчныг бохирдуулах, цаашлаад хүмүүсийн эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг аюул дагуулах эрсдэлтэй тул асуудлыг онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад болзошгүй осол нь дараах хэлбэрээр гарч болзошгүй. Шатах тослох материал, химийн хорт бодистой харьцаж ажиллах арга ажиллагааг мэдэхгүйгээс хөрс, гадаргын болон гүний ус, агаар цаашлаад ургамлан бүрхэвч, амьтанд ноцтой хохирол учруулж болзошгүй. Хордлогод өртөх зэрэг болзошгүй осол гамшиг тохиолдох магадлалтай.

Машин техниктэй холбоотой ажил эрхэлдэг ажилчин албан хаагчид машин техникийнхээ бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавихгүй, засвар үйлчилгээнд

хамруулахгүй байснаар шатах тослох материалын асгаралт гарч хөрс, гүний ус бохирдох, зөвшөөрөгдөөгүй замаар тээврийн үйл ажиллагаанд оролцсоноор ургамлан бүрхэвч талхлагдаж, хөрс эвдэрч, тоосжилт үүсэн агаарын чанарт нөлөөлж болзошгүй.

### ***Байгаль орчны сургалтын хөтөлбөр***

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой хөгжлийг дэмжих зэрэг үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй байлгах. Дээрх ажлын хүрээнд байгаль орчны сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж нийт ажиллагсдын экологийн мэдлэгийг дээшлүүлэх, байгаль хамгаалах үйлсэд ажилчдыг татан оролцуулах, компанийн байгаль орчны бодлого, хууль эрхзүйн дүрэм журмуудыг танилцуулах зорилгоор нийт ажилчдыг хамарсан байгаль орчны сургалт, мэдлэг олгох ажлуудыг зохион байгуулдаг.

Байгаль орчны сургалтын хөтөлбөрийн хүрээнд дараахь зорилтуудыг 2020 онд тавьж ажилласан. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлон тусгай сургалтын материалд тусгаж өгөх,
- Төслийн ажилтан бүр өөрийн хийж гүйцэтгэх ажлаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг мэддэг байх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх ур чадварт суралцахад дэмжлэг үзүүлэх,
- Байгаль орчны зөрчлийг цаг алдалгүй хэрхэн мэдээлэх, зөрчлийг дахин давтан гаргахгүй байхад ажилчдын оролцоог нэмэгдүүлэх,
- Байгаль орчныг хамгаалах талаар ОУ-ын байгууллагуудаас зарлаж буй Дэлхийн өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх,
- Байгаль орчны ажлын гүйцэтгэл, түүний биелэлтийн тайлан болон бусад мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, нээлттэй өдөрлөгүүдийг зохион байгуулах, зохион байгуулахад оролцох, мэдээллийн хуудас бэлтгэх

### **Болзошгүй аюул ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд**

#### ***Байгалийн гамшигаас үүсэх болон болзошгүй осол***

Байгалийн гамшигт газар хөдлөл, усны үер, салхи шуурга, аянга цахилгаан, гал түймэр, үйлдвэрлэлийн осол, халдварт өвчин тархах зэрэг үзэгдлүүд хамаардаг.

#### ***Газар хөдлөл***

Газар хөдлөл нь байгалийн гамшгийн хамгийн аюултай хэлбэрийн нэг бөгөөд газар хөдлөлийг урьдчилан тогтоож, мэдээлэх боломж муу. Газар хөдлөлийн үзэгдэл манай улсад харьцангуй цөөн тохиолддог боловч хаягдлын сан бусад барилга байгууламжийг шинээр барьж байгуулахдаа газар хөдлөлийн нөлөөллийг сайтар тооцох шаардлагатай. Газар хөдлөлийн улмаас шугам сүлжээ гажих, тасрах, барилга байгууламжид ан цав гарах, нурах, ус дамжуулах шугам хоолойнууд болон хаягдал дамжуулах хоолой эвдрэх, цоорох гэх мэт хохирол, сүйрэл гарч болзошгүй. Иймээс үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, газар доорх шугам сүлжээг барьж байгуулах болон суурилуулахдаа газар хөдлөлийн хэдэн балл хүртэл тэсвэрлэх чадвартай болон уг үйлдвэрлэлд тохирох эсэх талаар холбогдох мэргэжлийн байгууллагын үнэлгээ, дүгнэлт гаргуулан осол аваарын үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан.

### ***Салхи, шуурга***

Говийн бүс нутаг нь хавар, намрын улиралд, ялангуяа хаврын улиралд үе үе хүчтэй салхитай байдаг бөгөөд салхины хамгийн дээд хурд нь 20 м/сек-ээс хэтрэх тохиолдол тус бүс нутагт олонтаа тохиолддог. Иймээс хаврын улиралд үйлдвэрийн түүхий эд болон бүтээгдэхүүнийг тээвэрлэх, шатах тослох материал, агуулахыг байршуулах, үйлдвэрлэл явуулахад дээрхи нөлөөллийг сайтар харгалзан үзэх шаардлагатай. Хаягдлын байгууламжаас салхи, шороон шуурганы давтамж ихтэй хавар, намрын улиралд нарийн ширхэгтэй тоосонцор үүсч, агаарыг бохирдуулах магадлал өндөртэй. Мөн тухайн нутаг дэвсгэрт цаг агаарын олон жилийн дунджаар 15 м/сек-ээс их салхитай өдөр 10, шороон шуургатай өдөр 33, цасан шуургатай өдөр 10 удаа тохиолдож, салхины их хурд 16-34 м/сек, ялангуяа хаврын саруудад 28-34 м/сек хурдтай салхилах тохиолдол олон гардаг байна. Тиймээс тоосжилтоос сэргийлэх арга хэмжээг нарийн төлөвлөх шаардлагатай байдаг. Шороон шуурганы үргэлжлэх хугацаа жилд дунджаар 20 өдөр байгаа нь хаягдлын байгууламжийн үйл ажиллагааг хаах үед нарийн ширхэгтэй тоосонцор салхиар тээвэрлэгдэн тархах эрсдэлтэй байна. Ийм учраас хадархаг хөрсөөр хучилт хийх, мөн техникийн ба биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зохих шаардлагын дагуу хийх нь зүйтэй юм.

### ***Үер***

Үйлдвэрийн бүс нь олон жилд цөөн удаа тохиолдох үерийн аюулд бага өртөнө. Ус их цуглавал далангийн хаалт сэтгэрч, ихээхэн хэмжээний ус алдагдан орчныг бохирдуулахаас гадна түүнийг сэргээн босгоход шаардагдах цаг хугацаа, хүч хөдөлмөр, эд хөрөнгийн ихээхэн хохирол үүсч болзошгүйг анхаарах шаардлагатай. Зуны хур борооны үед цаг агаарын нөхцлөөс хамааран үерийн аюул үүсч болзошгүй тул далан хаалт сэтгэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх, үйлдвэрийн цогцолборын болон хаягдлын сангийн эргэн тойронд үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу, хамгаалах далан хаалт байгуулах нь зүйтэй. Үер усны аюул нь зарим тохиолдолд газар хөдлөлийн сүйтгэлээс багагүй хохирол учруулж, хүний амь нас эрсдэх магадлалтайгаас гадна байгаль орчныг бохирдуулах, үйлдвэрийн орчин ус, хөрс, ургамлан нөмрөгт ихээхэн хохирол учруулах нөхцөлтэйг мартаж болохгүй юм.

### ***Аянга цахилгаан***

Зуны улиралд, ялангуяа хур бороо элбэгтэй 7-8 дугаар саруудад аянга цахилгааны үзэгдлүүд илүүтэй тохиолдоно. Иймд үйлдвэрийн өндөр хүчдэлийн шугам бусад шаардлагатай газруудад аянга зайлуулагчийг байрлуулах шаардлагатай. Тус бүс нутагт зуны улиралд 20 орчим өдөр аянга цахилгаан буудаг байна. 1 кв.км талбайд 4-6 удаа аянгын ниргэлт болдог нь үйлдвэрийн болон уурхайн техник хэрэгсэл, хүмүүсийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн нөхцөлд түр саатал бэрхшээл учруулж, улмаар аюул осол тохиолдож болох магадлалтай. Иймээс шаардлагатай газарт аянга зайлуулагчийг байрлуулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад ажиллагсад металл хийц бүхий тоног төхөөрөмж, байгууламжаас аянга цахилгааны осолд өртөхөөс сэргийлэх шаардлагатай.

### ***Халдварт өвчин тархах***

Хатуу, шингэн хог хаягдлыг тогтоосон хугацаанд зайлуулахгүй, удаан хугацаагаар хуримтлуулан хадгалах, ил задгай байлгах, бохир усны цооног халих, хог хаягдлын цэг, жорлон, бохир усны цооногт тогтоосон хугацаанд ариутгал хийхгүй байх, хоол хүнсний хаягдлыг таггүй саванд ил хадгалах зэргээс орчны ус хөрс, агаар бохирдож, халдварт



өвчний нян өсч үржих, халдварт өвчин үүсэн тархах нөхцөлтэй. Мөн хоол хүнсийг зориулалтын дагуу зөв хадгалаагүйгээс хүнсний зүйл муудах, ундны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоогоогүйгээс ус бохирдох зэргээс гэдэс дотрын элдэв халдварт өвчин үүсч, тархах аюултай. Үйлдвэрийн хэмжээнд онцгой байдал, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний тусгай төлөвлөгөөтэй ажиллах шаардлагатай. Осол аваар гарах тохиолдолд яаралтай мэдээлэл дамжуулахын тулд холбогдох хүмүүсийн овог, нэр, хаяг, утсыг тусгайлан бичиж, тохиромжтой газар байрлуулах, энэ талаар ажилчдад тодорхой мэдээлэл өгсөн байвал зохино. Осол аваар гарсан үед түүний хугацаа, байршил, төрөл хэлбэр, хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл, хамрах цар хүрээг тогтоосны үндсэн дээр шаардагдах хүн хүч, хөрөнгө зардлыг тодорхойлж, ослын үр дагаварыг яаралтай арилгах болон цэвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Ослын хор уршгийг арилгасны дараа түүнийг бүрэн арилсан эсэхэд судалгаа хийж, хяналт тавих шаардлагатай.

### ***Галын аюул***

Гал түймэр гарах нөхцөл нь цахилгааны холболтыг буруу хийх, ачааллыг хэтрүүлэх, шалбарч гэмтсэн цахилгааны утас хэрэглэх болон ажиллагсдын хайнга байдлаас үүдэн гал алдах зэрэг болдог. Иймд цахилгаан тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны холболт хийх ажлыг мэргэжлийн байгууллагаар найдвартай хийлгэхийн зэрэгцээ ажиллагсдыг цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаанд сургаж дадлагажуулах хэрэгтэй. Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах, гал түймрээс сэргийлэх багаж хэрэгслийг гарын дор бэлэн байлгах нь зүйтэй.

### **БО-ны төлөвлөгөө болон БОНБНУ-д тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбогдсон арга хэмжээнүүд**

#### ***Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга зам, хийсэн ажил***

Төслийн дотоод болон гадаад замыг тоос харьцангуй бага босгодог материалаар хучих, замыг хатуу хучилттай болгох, хуурайшилт ихтэй үед зам услах, олон салаа зам гаргахгүй байх тал дээр анхааран ажиллаа, уурхайн замаар зорчих хурдны хязгаарыг тогтоох зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.

#### ***Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх нөлөөллийг бууруулах***

Газар ашиглалтын хяналтыг сайжруулж, шаардлагагүй ашиглалтыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Ашигласан тосыг маслыг 10тн-ийн ёмкостинд цуглуулан дахин боловсруулдаг аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэн өгдөг. Зогсоолын талбайг Tonli, Terex хүнд машин механизмын гэж төрөлжүүлэн тухай бүрт нь бохирдосон хөрсийг цэвэрлүүлж байна. Мөн түүнчлэн ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тогтоосон цэгт зохих журмын дагуу зайлуулдаг. Үржил шимт хөрсийг газар хөндөх үйл ажиллагааны өмнө тогтмол хуулан овоолго үүсгэн хадгалах, нөхөн сэргээлтэнд эргүүлэн ашиглах зэргээр өнгөн хөрсийг эрэлтэнд оруулж байна.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал, сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	<b>Агаарын чанар:</b> Уулын ажлын үеийн газар шорооны ажил, техникийг зөөх зэрэг үйл ажиллагааны явцад үүсэх хөрсний эвдрэлээс босох тоосжилт нь орчны тоосжилтыг нэмэгдүүлэх	1.Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааг оновчтой зохион байгуулах, технологийн замууд болон овоолго зэргийг усалж чийглэх, хуурайшилттай үед усалгааг ойртуулах, усалгааг явуулахдаа уурхайгаас шавхан зайлуулах ус ашиглан тоосыг бууруулж ажиллана.	Уурхайн зам-1.89га Овоолго-141.9га Зүлэг-0.074га Мод үржүүлгийн талбай /15000ш мод/ услах	га	1.0	4	4.0	2023 онд жилийн турш	Агаарын тухай хууль 18-р зүйл, MNS5885:2008 MNS4585:2007
		2.Ил уурхайн карьерт тээвэрлэлт хийх машины хурдыг хязгаарлаж 30 км/цагаас хэтрүүлэхгүй байх, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах ажилд хяналт тавих.	Төсөлд ашиглагдаж буй замууд	-	ҮЗ	-	-	2023 онд жилийн турш	
		3.Нүүрс тээврийн ачааны хэсгийг бүтээлэгтэй байлгах тал дээр анхаарч, шаардлага тавьж ажиллах.	Төслийн хүрээнд	-	ҮЗ	-	-	2023 онд жилийн турш	
2.	<b>Гадаргын ба газрын доорх усны нөөц:</b> Гадаргын болон газрын доорх усны нөөцөд нөлөөлөл үзүүлж болзошгүй	1.Жил бүр үйлдвэрийн болон ахуйн усны хэрэглээний тооцоо хийж, ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай хийх.	Төслийн хүрээнд	Гэрээ, дүгнэлт	0.7	2	1.4	2023 оны 1-р улиралд	
		2.Уурхайн ус шавхан зайлуулалд хийхэд ашиглаж буй насосын тоолуурын хэвийн ажиллагаанд байнга хяналт тавих.	Төслийн хүрээнд	Жилд	0.1	12	1.2	2023 онд жилийн турш	

3.	<b>Хөрсөн бүрхэвч:</b> Төслийн талбай болон түүний эргэн тойрны тээврийн хэрэгсэл хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн, доройтох	1.ШТМ-ыг асгарч байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах.	Төслийн хүрээнд, засварын талбай	-	ҮЗ	-	-	2023 онд жилийн турш	Хөрс хамгаалах тухай хууль, газрын тухай хууль
		2.Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх, байгаль орчныг хамгаалах самбар байрлуулах.	Төслийн хүрээнд	-	1.0	1	1.0	2023 онд жилийн турш	
		3.Хөрсний овоолго болон ил уурхайн тэлэлт хийхэд тухайн хэсгийн шимт хөрсийг стандартын дагуу хуулж авах.	Төслийн хүрээнд	-	ҮЗ	-	-	2023 онд жилийн турш	MNS5916:2008
		4.Шатах тослох материал хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж тохижуулах	Төслийн хүрээнд	-	2.5	1	2.5	2023 онд жилийн турш	-
4.	<b>Газрын хэвлий:</b>	1.Байгууламжуудтай холбоотой бий болсон газрын эвдрэлийг багасгах, засах, уурхайн үйл ажиллагаанд өртсөн зам талбайнуудад тухай бүрд нөхөн сэргээлт хийнэ.	Төслийн хүрээнд,	Тухай бүрт	ҮЗ	Тухай бүрт	-	2023 онд жилийн турш	MNS5916:2008
5.	<b>Ургамлан нөмрөг:</b> Төслийн үйл ажиллагаа явагдах орчинд ургамлан бүрхэвч сүйтгэгдэж, доройтно.	1.Олон салаа зам ургамлан нөмрөг, хөрс эвдэх аюултай тул авто техникийн хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулж хяналт тавина.	Уурхайн дотоод замууд	-	ҮЗ	-	-	2023 онд	Газрын тухай хууль
		2.Тухайн бүс нутгийн онцлогт тохирсон болон зонхилогч ургамлыг тарих бодлого баримтлах.	Төслийн хүрээнд,	Улирал	1.0	2	2.0	2023 онд	Ургамал хамгааллын тухай хууль
6.	Амьтны аймаг:	1.Төслийн талбайд мал амьтан орж, машин механизмд дайруулж хорогдохоос сэргийлж, байнгын хараа хяналт тавих.	АМТЗ-ийн талбайд	-	-	-	-	2023 онд	Амьтны тухай хууль
	Нийт						<b>12.1</b>		

## Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ

### 1. Агаарын чанар

1.1 Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааг оновчтой зохион байгуулах, технологийн замууд болон овоолго зэргийг усалж чийглэх, ногоон байгууламж нэмэгдүүлэх хуурайшилттай үед усалгааг ойртуулах, усалгааг явуулахдаа уурхайгаас шавхан зайлуулах ус ашиглан тоосыг бууруулан ажиллаж байна. /Усны цистерн 25тн болон 20тн/



1.2 Ил уурхайн карьерт тээвэрлэлт хийх машины хурдыг хязгаарлаж 30 км/цагаас хэтрүүлэхгүй байх, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах ажилд ХАБЭА хэсэгтэй хамтран байнга хяналт тавин ажиллаж байна.



1.3 Нүүрс тээврийн ачилтын хэсгийг бүтээлэгтэй байлгах тоосжилтыг бууруулах зорилгоор “EMBRACE” ХХК гэрээ байгуулан байнга хяналт тавин ажиллаж байна.

### Нүүрс бүтээлэг



## 2. Гадаргын ба газрын доорхи усны нөөц

### Ахуйн усны хэрэглээ

Худгийн код	Байршил	Усны тоолуур	Цооногийн гүн /м/	Ашиглалтын хэлбэр
46150	Төв оффис	Байгаа	100	Ахуйн хэрэгцээнд
46150-02	Төв оффис	Байгаа	70	Ахуйн хэрэгцээнд
46150-03	Уурхайн тосгон	Байгаа	140	Ахуйн хэрэгцээнд

Худаг №46150



Худаг №46150-02



Худаг №46150-03



### Усны тоолуур



Ундны ус цэвэршүүлэх хоёр байгууламж, ахуйн ус цэвэршүүлэх нэг байгууламж, ахуйн бохир ус цэвэрлэх нэг байгууламжаар өөрийн хэрэгцээгээ 100% хангадаг бөгөөд угаалга, цэвэрлэгээ, угаалтуур, халаалтын систем, ногоон байгууламж зэрэг ахуйн усан хангамжийн ашиглалтад 3 цооног байдаг. 2023 онд унд болон ахуйн усны хэрэглээнд хяналт тавьж ажилласан бөгөөд 2022 оны 12-р сарын 15-наас 2023 оны 10-р сарын 25-ны байдлаар унд ахуй, ногоон байгууламжид **16896 м<sup>3</sup> усыг** ашиглаж байна.

## Ундны ус болон ахуйн ус цэвэршүүлэх байгууламж

### Ундны ус цэвэршүүлэгч



Ахуйн ус цэвэршүүлэгч

Цэвэр ус



### Өөрийн 3 худагт мониторинг хийж байна



## ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ

Төмөр бетон хийцийн “БИОТЕХ 150 Х.Н. С90” ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж  
/ ATV-A122 OENORM 2502-2 дагуу/

“БИОТЕХ 150 Х.Н.” цэвэрлэх байгууламж нь биологийн цэвэрлэгээний аргаар хоногт 150 хүний 22,5 м<sup>3</sup> бохир усыг нүүрс усны задралын хувьд 90% цэвэршүүлэх хүчин чадалтай.

Байгууламжийн төлөвлөлтийг Монгол улсын Стандартчилал хэмжил зүйн төвөөс баталсан “Бага хүчин чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжын MNS EN 12566:2011” стандарт болон ХБНГУ-ын жижиг оврын 51-ээс 500 хүний бохир ус цэвэрлэх байгууламжийг төлөвлөх ATV-A122, Австри улсын OENORM B-2502-2 норм дагуу хийв.

Хоногт нэг хүний хэрэглээг 150 л усаар төлөвлөж, үүнд 300 мг/л БХХ5\* буюу химийн хуурай жинлэгдэх бодисоор 190 гр бохирдол орохоор тооцов. Уг бохирдлыг механик цэвэрлэгээний дараа биологийн аргаар цэвэрлэхэд хоногт нэг хүнд 60 гр БХХ5 зарцуулснаар 40мг/л хүртэл цэвэршүүлэх үндсэн нөхцлөөр байгууламжын төлөвлөлтийг хийв.

Бохир усны цэвэрлэгээний үр дүнг MNS 4288-2000-ын 3-ын 3-т заасан шалгуур үзүүлэлттэй харьцуулан үнэлэхэд энэ шалгуурыг хангасан байна. Өөрөөр хэлбэл 90% цэвэршилттэй байна.

Өдөрт 22.5 м<sup>3</sup> цэвэршсэн бохир ус өвөл зуны аль ч улиралд хоёрдогч тунгаагуураас шингээлтийн сувагаар дамжин хөрсөнд шингэнэ.

### Байгаль орчны нөлөөлөл

Ийнхүү 300 мг/л БХХ5 бохирдолтой бохир усыг 30 мг/л хүртэл цэвэршүүлсний дараа хөрсөнд шингээх нь хөрсний ус болон ойр орчныхоо цэвэр усны худгийг бохирдуулахгүй байх үндсэн нөхцөлийг бүрдүүлнэ. Энэ нь Монгол улсад мөрдөгдөж байгаа стандартад бүрэн нийцнэ.

### Техникийн үзүүлэлтүүд

#### А. Байгууламж

Цэвэрлэгээний процесс нь бохир усны оролт, цэвэршсэн усны гаралтын байнгын тэнцвэрт урсгалын явц дунд тусгай тоноглолууд / хөвөгч бодис баригч хаалт, хүчилтөрөгчжүүлж хутгагч систем, илүүдэл лаг буцаагч/ бүхий төмөр бетон хийцийн 3 тусгай савнуудад явагдана.

Байгууламжийг анх ашиглахдаа биологи цэвэрлэгээний цооногийг аэроб бактерийн тусгай бэлдмэлээр цэнэглэж, тэдгээрийн зохистой үржих нөхцлийг хүчилтөрөгчжүүлж хутгах системийн тусламжтайгаар хангасан болно.



Хоногийн цэвэрлэх хүчин чадал	150хүн нэгж /х.н./ буюу 22,5 м <sup>3</sup> бохир ус
Бетон савны нийт эзлэхүүн <u>1. Механик урьдчилсан цэвэрлэгээ</u> Гүн Гадаргуу(м3/х.н.)	90 м <sup>3</sup> 22,5 м3 2.5м 0.1
<u>2. Бактер идэвхжүүлэх сав</u> Хүчилтөрөгч оролт(кг/хоног) Хүчилтөрөгчжүүлж хутгагч системийн хүчин чадал Хутгалт Гаралтын хэсгийн хэсгийн хүчилтөрөгчийн агууламж Агааржуулалт/амралтын интервал	45,0 м3 41.5 1150 Вт 220 V 24 м3/цаг 2мг/л 60 мин/45мин 10м3
<u>3. Бактер тунгаах байгууламж</u> Лаг буцаах систем	450 вт
Бетон хийцийн зузаан	25 см
Гаднах бохир дамжуулах хоолойн материал	PVC
Дамжуулах хоолойн диаметр	DN 160,PVC,Герман
Бохир усны урсгалын дундаж ачаалал	2,2 м <sup>3</sup> /цаг
Хүн нэгж ноогдол	150 л бохир ус /хоног
Нэгж бохирдолт	60 гр БХХ <sub>5</sub> х.н. хоног
Хоногийн цахилгаан зарцуулалт	26,4 кВт/хоног
Бактерийн индекс	75-150 мл/гр
Бохир усны оролт/буцах лагийн харьцаа	1,0
Цэвэршсэн усыг хөрсөнд шүүж шингээх байгууламж Нийт талбай Анхдагч нийт эзлэхүүн Шингээлтийн хоолойн урт Шингээлтийн сувгийн материал Шингээлтийн сувгийн суултын гүн	100м2 250м3 100м PVC, DN 110 2,8м
Хэт яагаан туяаны ариутгагч	4x36вт,200-280нм, 260нм max

### Б. Бохирын оролтын үеийн /үнэмлэхүй/ бохирдолт

Биохимийн хүчилтөрөгчийн хэрэгцээ / БХХ <sub>5</sub> /	9,0кг/хоног
Химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ /XXX/	18,0 кг/хоног
pH – утга	6-7
Дээд температур,зундаа	40°С
Доод температур,өвөлдөө	8°С
Нийт химийн хуурай усгүй жинлэгдэх бодис	28,5 кг/хоног
Нийт азот	55 мг/л



В. Цэвэрлэгээний үр дүн

Биохимийн хүчилтөрөгчийн хэрэгцээ / БХХ5 /	<30 мг/л (>90%)
Химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ /XXX/	<60 мг/л
рН – утга нийт азот фосфат	Саармаг 10мг/л /1000 хүнээс доош байгууламжинд хянах шаардлага тавигддаггүй/ Мөн 1000 хүнээс доош бол хянах шаардлага тавигддаггүй

Г. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Суултуур, тосгуур руу элдэв механик хог хаягдал, нийлэг материалаар хийсэн салфетка, уут сав, эмэгтэй хүний ариун цэврийн хэрэгсэл, архи, пивоны бөглөө, тамхины иш зэргийг хийхийг хориглоно. Эдгээр нь биологийн задралд орохгүйгээс гадна шахуургын дамарт орооцолдох, гацаах, хоолойг бөглөх зэрэг аюултай. Мөн халдваргүйжүүлэх, ариутгалын бодисууд, хортон шавьж устгалын бодисууд, хүчил, шүлт, антибиотикийн бэлдмэл хийхийг хориглоно. Үүнээс гадна угаалгын ажиллагаанд элдэв цайруулагч бодис, ялангуяа хлорт нэгдлүүд, тухайлбал хлорын хэт исэлийг өндөр тунгаар тогтмол хэрэглэхийг хориглоно.

Д. Ашиглалт, арчилгаа, үйлчилгээ

Цэвэрлэгээний процессыг явуулахдаа бохир усны агаарын хүчилтөрөгчийн хангамжийн болон илүүдэл бактер буцаах системүүдийн уялдаатай ажиллагааг зохистой горимоор автоматжуулсан тул байгууламжийн ашиглалтын явцад механик болон биологийн цэвэрлэгээний ниит дамжлагуудад байнгын арчилгаа, үйлчилгээ шаардагдахгүй.

Өдөр тутам нэг хүн агааржуулалтын болон лаг буцаах шахуургын хэвийн ажиллагааг шалгаж байх хэрэгтэй.

Долоо хоногт нэг удаа хог баригчийг авч цэрэрлэх шаардлагатай.

Жилд нэг удаа илүүдэл лагийг лагийн талбай руу зохих зааврын дагуу гадагшлуулах хэрэгтэй.

Хоёр жил тутамд хэт яагаан туяаны төхөөрөмжийн лампыг солих шаардлагатай.

Е. Баталгаат хугацаа

Бетон байгууламжийн баталгаа	40 жил
Цахилгаан тоног төхөөрөмжийн баталгаа	24 сар

### Уурхайн шүүрлийн ус:

Хүрэн толгой уурхайн ашиглалт ухалтын явцад шүүрсэн усыг уурхайн мөргөцөгт байгуулсан дренаж ашиглан хамгийн доод талын зүмпэнд хуримтлуулан усны 2 ш автомашинаар зөөвөрлөн нөхөн сэргээлтийн усалгаа, тоосжилтыг бууруулахад ашигладаг ба жилийн зарим үед уурхайд орж ирэх усны хэмжээ харилцан адилгүй бөгөөд эсвэл огт шүүрэхгүй болдог, энэ нь тухайн жилийн хур тунадаснаас ихээхэн шалтгаалж байдаг.

2023 онд ус ашиглах дүгнэлт, гэрээний дагуу уурхайн шүүрлийн ус нийт 56713.7 м<sup>3</sup> гарсан.

Ус ашиглах тооцоо:

- Зам, талбайн усалгаа-15120м<sup>3</sup>
- Мод, ногоон байгууламжийн усалгаанд: 2700 м<sup>3</sup>

Уурхайн шүүрлийн усыг ус ашиглах дүгнэлт, гэрээний дагуу 2022 оны 12-р сарын 15-наас 2023 оны 9-р сарын 25-н хүртэл **47261.4** м<sup>3</sup> усыг дүгнэлт, гэрээний дагуу ашиглаад байна. Мөн төрийн байгууллагуудын шаардлагаар болон хэрэглээгээ хянах зорилгоор шүүрлийн ус хуримтлуулсан хэсгээс автоцистернд /усалгааны машин/ ус шахах насос ашиглан зам талбайн тоосжилт болон ногоон байгууламжийн усалгааг хийж байна.

### *Шүүрлийн ус*



**2.1** Жил бүр үйлдвэрийн болон ахуйн усны хэрэглээний тооцоо хийж, ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай хийсэн.

Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-аар 2023 оны 04 сарын 04 өдөр Дугар 05/341 тоот “Ус ашиглах дүгнэлт гаргуулан хүлээн авсан. /Дүгнэлт хавсаргав /

Үүний дагуу “Алтайн өвөр говийн сав газар”-тай “ус ашиглах гэрээ” болон “Хаягдал усны дүгнэлт” гаргуулах албан бичиг хүргүүлж. 2023 оны 04-р сарын 10нд ус ашиглах зөвшөөрөл, ус ашиглах гэрээ 23/08 дугаар гэрээг байгуулсан. Хаягдал усны дүгнэлтийг 2024 оны 1-р улирал гаруулах албан тоот хүлээн авсан./Гэрээ хавсаргав./

**2.2** Уурхайгаас ус шавхан зайлуулалд хийхэд ашиглаж буй насосын тоолуурын хэвийн ажиллагаанд байнга хяналт тавих.

2023 онд унд, ахуйн болон уурхайн шүүрлийн усны хэрэглээнд хяналт тавьж ажилласан бөгөөд сар бүрийн 25нд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Байгаль хамгаалагч А. Бүжинтэй хамтран усны төлбөр, усны тоолуурын хяналтын акт үйлдэн баталгаажуулалт хийж байна.

### **3. Хөрсөн бүрхэвч**

**3.1** ШТМ-ыг асгарч байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах.

Бохирдсон тос, тослох материалыг уурхайн тосгоны зүүн урд байрлах тос солих цэгт бэлтгэсэн 30 тонн багтаамжтай ёмкост хийж, хөрсний бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллаж байна. /Хөрсний хяналт, тослох материалын хадгалалт/

“Монпити ойл” ХХК-тай хаягдал тос, гидрийн шингэн нийлүүлэх гэрээг байгуулан ажиллаж байна. Нарийн сухайтын уурхайтай хамтарсан байдлаар хаягдал тосоо акт үйлдэн хүлээлгэн өгөхөөр харилцан тохироод байна. Аюултай хог хаягдлыг тусгай цэгт байршуулаад байна.

*Бохирдсон тос, тослох материалын хадгалалт, хөрсний хяналт*



### 3.2 Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх.

Зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээврийн үйл ажиллагаа явуулж, уурхай доторх шороон замуудыг нөхөн сэргээж, хөрсний сул шороо агаарт дэгдэж тоосжилтыг нэмэгдүүлэх, улмаар ургамалд дам нөлөөлөхөөс тогтмол хугацаанд урьдчилан сэргийлж ажиллаж байна.

*Уурхай доторх зам талбай нөхөн сэргээлт, цэвэрлэх*



*Зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээврийн үйл ажиллагаа*



**3.3** Хөрсний овоолго болон ил уурхайн тэлэлт хийхэд тухайн хэсгийн шимт хөрсийг хуулж тусгайлан бэлтгэсэн талбайд хадгалах.

Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт MNS 5916:2008 стандартын дагуу ордын ТЭЗҮ болон БОНБНҮ –ний тайланд тусгаснаар үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт хамгаалалт болон хэлбэржүүлэх ажлыг хийсэн бөгөөд салхинд хийсэж чийг үржил шимээн алдахаас сэргийлж карьераас ус, мөс зөөн авчран байнгын усалж чийглэж байсан. Хүрэн толгойн уурхайн жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөнд оруулан гүйцэтгэж байна.

Хүрэн толгойн уурхайн ашиглалтын явцад шимт хөрс хуулж хадгалж байгаа бөгөөд 2022 онд дээрх шимт хөрсний овоолгыг хэлбэржүүлэн засах нүүлгэн шилжүүлэх ажлыг хийж байгаа бөгөөд 2023 онд хөрсний үржил шимийг нь хадгалах зорилгоор тарьсан мод бутыг арчлан, хуурайшиж салхинд хийсэхээс хамгаалж дараах ажлыг зохион байгуулсан.

*2023 оны 18.2 га талбайн шимт хөрс хуулан авч, 14800м<sup>3</sup> хөрс хадгалалт болон хэлбэржүүлэлт хийсэн*



*Шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, хэлбэржүүлэлт*



### 3.4 Шатах тослох материал хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж тохижуулах.

Бохирдсон тос, тослох материалыг уурхайн тосгоны баруун урд байрлах тос солих цэгийг 2022 онд уурхайн тосгоны зүүн талд нүүлгэн шилжүүлж 30 тонн багтаамжтай ёмкос байрлуулж талбайг бетондуулсан. 2023 онд тохижуулах ажилд шатах тослох материалаар бохирдсон хөрсний хатаах талбайг зутгаж бетондуулсан.

Өмнө



Дараах



*Тос солих цэгийг 10 метр өргөн 16 м урт /24м<sup>3</sup>/ бетон зутгаж хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлж байна.*



*Бетон зутгах ажлын гүйцэтгэл /өргөн-4м, урт-10м, зузаан-8 см/ 40м<sup>2</sup>*



#### 4. Газрын хэвлий

4.1 Байгууламжуудтай холбоотой бий болсон газрын эвдрэлийг багасгах, засах, уурхайн үйл ажиллагаанд өртсөн талбайд тухай бүрд нөхөн сэргээлт хийнэ.

*2023 онд мод үржүүлгийн талбайн мод, бутыг шилжүүлэн суулгаж талбайг чөлөөлж /1.4 га/ техникийн нөхөн сэргээлт*

*Засахын өмнө*



*Дараа*



#### 5. Ургамлан нөмрөг

5.1 Олон салаа зам нь ургамлан нөмрөг, хөрс эвдэх аюултай тул авто техникийн хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулж хяналт тавина.

Зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээврийн үйл ажиллагаа явуулж, шороон замуудыг нөхөн сэргээж, хөрсний сул шороотой зам талбайг усалгаа хийж агаарт дэгдэх тоосжилтыг бууруулан ажиллаж байна.




5.2 Тухайн бүс нутгийн зонхилгч ургамлыг тарих, туршилт судалгаа явуулах. Зонхилгч ургамлын үрийг тарих туршилт судалгааг хийх. Энэ үр дүнгээс хамаарч ямар ургамлын үрийн санг түлхүү үүсгэх.

Манай компани нутгийн унаган ургамал болох сухайг 2005 оноос хойш тарималжуулан ургуулж байгаа бөгөөд нөхөн сэргээлтэд хамгийн тохиромжтой нь сухай, жигд гэсэн дүгнэлтэд хүрээд байна. Энэ нь тухайн ургамлын биологийн онцлог болоод ургах орчинтой холбоотой юм. Биологийн онцлогийг нь ашиглаж карьерын салхин дээд талд нь тарьж эхэлсэн бөгөөд үр жимс боловсорч гүйцээд салхины нөлөөгөөр ургах таатай нөхцөл бүрдэн бий болсон газарт /карьер/ ургаж байна. Өөрөөр хэлбэл салхин талд нь

тарьсан сухайн боловсорч гүйцсэн үр нь карьерын гулсалтын чийглэг, нөмөрлөг газарт салхины аясаар туугдан унаад бие даан ургаж байгаа юм.

*Уурхайн карьерт ургасан сухай, жигд*



Мөн 2018 оноос эхлэн царгас тарьж туршилт хийгээд байна. Царгас нь хөрсний үржил шимийг байнга дээшлүүлж байдаг. Энэ нь байгаль орчинд үзүүлж байгаа нэг чухал сайн нөлөө мөн. Сүүлийн жилүүдэд газар тариалангийн атаршуулж орхисон талбай, мөн уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн талбайг царгас тариалах замаар нөхөн сэргээдэг олон улсын туршлага юм. Царгасыг 0.6 га талбайд тариалаад 2 дахь жилээс нь эхлэн боловсорч гүйцсэн үед нь 3 удаа хурааж авсан бол 4 дахь жил буюу 2021-2023 онд 4-5 удаагийн ургац авч малчин иргэдэд өгч арга туршлагаасаа хуваалцаж байна. Уурхайн нөхөн сэргээлт болон гадна тохижилтод ашиглах бүрэн боломжтой ургамал гэсэн дүгнэлтэд хүрээд байна.

*Царгас ургалт болон хураалт*





*Хайлаас, агч, жигд, заг модны үр түүж бэлтгэх ажил 20кг*



### 6. Амьтны аймаг

Төслийн талбайд мал амьтан орж, машин механизмд дайруулж хорогдохоос сэргийлж, байнгын хараа хяналт тавих.

2023 онд хур бороо багатай гандуу байгаа улмаас 11-р сард хар сүүлт 4-5-аар сүрэглэн уурхайн мод үржүүлгийн талбайд идэш тэжээл хайн орж ирсэн. Үүний дагуу манай компани нь өвс тэжээл болон ус тавьж өгөөд байна. Төслийн талбайд мал амьтан орж, машин механизмд дайруулж хорогдохоос сэргийлж, байнгын хараа хяналт тавин ажиллаж байна.



### **3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

#### **Биологийн нөхөн сэргээлт**

Манай компани үйл ажиллагаа эхэлсэн 2003 оноос хойш 20 жилийн хугацаанд уурхайн мод үржүүлгийн талбайд болон ажилчдын хотхоны тохижилт зэрэгт жигд, сухай, бургас, улиас, гацуур, голт бор зэрэг нийт 15000 мод, сөөг тарьж ургуулан арчлан хамгаалж байгаа бөгөөд одоогийн байдлаар нийт ургаж байгаа модны өндөр нь 6 м, дунджаар 3.5 м орчим байгаа бөгөөд жигдийн 90 орчим хувь нь үр жимсээ өгч байна. 2020 оны хувьд сухай болон жигд бусад модны ургалт хэвийн байсан бөгөөд өмнөх жилийн үзүүлэлттэй ижил титэм салаалалтын хувьд 20-55 см, улаан сухай 10-18 см, бургас 30-60 см ургасан. Эдгээр модноос тайралт хийн мөчрөөр нь үрслүүлэн плантци байгуулах боломж бүрдсэн. Үүнээс гадна дээрх модны үр жимс нь боловсорч гүйцэх, ургах орчин нь олон тооны үр идэшт шувуудын амьдрах таатай нөхцөл болоод байна. Мөн шувуудын амьдрах орчинг улам сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Энэ хугацаанд говийн нөхцөлд дасан зохицсон модлог ургамлыг тарьж ургуулахыг зорилго болон ажилласан бөгөөд тухайн орчинд хамгийн сайн зохицон ургаж нутагшиж байгаа ургамал бол жигд, сухай юм.

Манай компани нутгийн унаган ургамал болох сухайг 2008 оноос хойш тарималжуулан ургуулж байгаа бөгөөд нөхөн сэргээлтэд хамгийн тохиромжтой нь сухай, жигд гэсэн дүгнэлтэд хүрээд байна. Энэ нь тухайн ургамлын биологийн онцлог болоод ургах орчинтой холбоотой юм. Биологийн онцлогийг нь ашиглаж карьерын салхин дээд талд нь тарьж эхэлсэн бөгөөд үр жимс боловсорч гүйцээд салхины нөлөөгөөр ургах таатай нөхцөл бүрдэн бий болсон газарт /карьер/ ургаж байна. Өөрөөр хэлбэл салхин талд нь тарьсан сухайн боловсорч гүйцсэн үр нь карьерын гулсалтын чийглэг, нөмөрлөг газарт салхины аясаар туугдан унаад бие даан ургаж байгаа юм.

2013 онд “Хүрэн толгой коал майнинг” ХХК-ийн ашиглалтын талбайн, ойжуулах, нөхөн сэргээх газрын ургамал, төрх байдлын судалгааг МУИС, БИОЛОГИ, БИОТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ-тай хамтран хийсэн. Энэхүү судалгааг 2013 оны 8-р сарын 27 оос 9-р сарын 10г хүртэл гүйцэтгэсэн бөгөөд энэ судалгаа шинжилгээний хариу болон дүгнэлтийн дагуу 2023 оны нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулан ажилласан болно.

## Судалгааны зорилго

“Хүрэн толгой коал майнинг” ХХК-ийн ашиглалтын талбай, ойжуулах, нөхөн сэргээх газрын ургамал, төрх байдлыг судалсан.

Судалгааг 2013 оны 8-р сарын 27-оос 9-р сарын 10 хүртэл гүйцэтгэсэн. Судалгаа хийсэн нутаг гандуу, ялангуяа Ноён, Гурвантэс сумын нутаг их гантай бас намар орой болж ургамал шарлаж хатсан, судалгааны талбай хоорондоо их том, нэг сумаас нөгөө сум хүртэл хол зам (100-300 км зам) туулдаг байв. Мөн түр зуурын бороо, хүчтэй салхи, шороон шуурга, аагим халуун гээд ажиллахад төвөгтэй байгалийн үзэгдэл байнга тохиолдож байлаа. Бидний гол зорилго бол Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр дэх ургамлын бүлгэмдэл, зүйлийн бүрдэл, тухайлбал ашигтай, хөнөөлтэй ургамал, нэн ховор ургамал хаана байгааг тогтоох ажил байсан. Гэтэл судалгааны зардал гараагүй, дөнгөж 6-7-р сард шийдвэр гарсан ч юуны өмнө хөрөнгө зардал гаргаж, хүсэлт даалгавар ирүүлсэн уул уурхайн компаниудын нутаг дэвсгэрт судалгаа хийх боломж нээгдсэн. Тэгээд 8-р сарын сүүлчээр 9-р сарын дунд үе хүртэл гүйцэтгэв. Уг нь ургамлын зүйлийн бүрдэл, тархалт ач тус, хөнөөлийг судлах ажлын тухай нутаг дэвсгэрт бүр 4-5-р сараас эхлэн 9-р сарыг дуустал ажиллах шаардлагатай байдаг. Нутаг дэвсгэрийн хэмжээнээс шалтгаалж зардал хөрөнгө их, бага гарна. Ажиллах хүч, судлаачдын зардал тэдний тоо, мэргэжлээс, туршлагаас шалтгаалж өөр өөр гарна. Харин унаа машинд зардал түүнээс 2-3 дахин их гардаг. Тэгээд зам хоног, зочид буудал, шуудан харилцаа, ариун цэвэр гээд хөрөнгө зардал гардаг.

Ийм их зардал гаргасан тохиолдолд мэргэжлийн өндөр боловсролтой, ажлын туршлагатай хүмүүсийг оролцуулах, баг бүрдүүлэх нь чухал. Ажлын үр дүн үнэмшилтэй, бодитой гардаг. Яагаад гэвэл тэд газар дээр нь судалгаа хийж сурсан, бас ургамлын зүйлийг ялган таних туршлагатай, ээдрээтэй асуудлыг шийдвэрлэх арга барилтай байдаг. Үүгээрээ тэд орчин үеийн компьютер, интернэт шүтсэн залуу эрдэмтэд, судлаачдаас давуу талтай, ажлын үр дүн үнэмшилтэй байдаг. Орон нутгийн ургамал судлах ажилд шинжлэх ухаанд нийтээр хэрэглэдэг олон нарийн арга хэргэлдэг. Тухайлбал ургамлын зүйлүүдийг ялгаж таньдаг байх, ургамлын бодгаль хөгжлийн үе шатыг ялган мэддэг байх, тодорхой талбайд эзлэх хувь, тохиолдоц, бүрхэц, өндөр нам, нас, амьдрах хэлбэр, ач холбогдлыг тогтоох хэрэгтэй байдаг. Үүний тулд тухайн газар нутаг аймаг, сум, баг ямар нэртэй газар, гадаргын өндөр, нам, хэвгий, налууугийн чиглэл, хөрсний бүтэц, ургах орчин зэргийг хэдэн оны хэдэн сарын хэдэнд хэн үйлдсэн болохыг дэлгэрэнгүй бичиж авдаг, ургамлын цуглуулга-хавсралтаа заавал хавсаргадаг. Ургамлаа зөв цуглуулах, сайхан хатаах их ажил байдаг. Тэр цуглуулга нь тухайн орон нутаг, сум, аймаг, хотын музей, эрдэм шинжилгээний газар эд мөрийн баримт болон хадгалагддаг учиртай.

## Уурхайн орчимд

Зонхилогч ургамлууд нь морин зээргэнэ-*Ephedra przewalskii*, Шар хотир-*Zygophyllum xanthoxylon*, Монгол торлог-*Calligonum mongolicum*, Монгол хулан хойрго-*Potania mongolica*, Зүүн гарын улаан бударгана-*Reaumurea soongarica*, Улаан сухай-*Tamarix ramosissima*, Ахар навчит баглуур-*Anabasis brevifolia*, Монгол бүйлс-*Amygdalus mongolica*, Алтан харгана-*Caragana leucophloea*, Шар шарилж-*Artemisia xanthocroa*, Сибирь хармаг-*Nitraria sibirica*, Гялгар дэрс-*Achnatherum splendens*, Гоолиг бадаргана-*Kalidium gracile*, Таана-*Allium polyrrhizum*, Хөмүүл-*Allium mongolicum*, Сайрын хялгана-*Stipa glareosa*, Говийн хялгана-*Stipa gobica*, Пеллиотийн шивэлз-*Ptilogrostris peliotii* зэрэг ургамлууд элбэг тохиолдоно.

*Хотир*



*Улаан бударгана*



*Шар хотир*



*Хунчир*



### Жигд-*Elaeagnus.L* юм.

#### Биологийн онцлог, ургах орчин



Жигд нь цөлийн ургамал бөгөөд цөл, баян бүрд, марзтай хотгор, элсэн манханы дундах чийглэг хонхор, уулын ам хавцлын задгай ус, булаг шандын зах хөвөө орчмоор давсархаг газар ургана. Манай оронд Алтайн өвөр говийн Эхэн зулганай, Алашаа говь, Хөвдийн баянбүрдүүдээр нийтдээ ердөө жараадхан ширхэг ургадаг, нэн ховор ургамал юм.

- Жигд нь дунджаар 4-6 м өндөр, 40-өөд см бүдүүн иштэй
- 5-р сарын эхээр цэцэглэнэ
- 4 наснаасаа цэцэглэж эхлэх ба 8 насандаа үрийн ургац нь жигдэрнэ
- Жил бүр үрлэнэ. /ЖИГД тарьж ургуулах гарын авлага Х. Жалбаа (Ph.D)2010 он Улаанбаатар хот/

### Сухай-*Tamarix L.*



#### Биологийн онцлог, ургах орчин

Сухай нь говь цөлийн ургамал. Халуун ба хужир давс сайн тэсвэрлэдэг элсэнд дарагдах тусмаа ичмэл нахианаас сэргэн ургах чадвар нь нэмэгддэг биологийн онцлогтой. Манай орны хувьд найман төрлийн сухай ургадаг. Зарим сухайн жилд 2 удаа цэцэглэдэг онцлогтой.

/СУХАЙ тарьж ургуулах гарын авлага

Х. Жалбаа (Ph.D)2010 он Улаанбаатар хот

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт: ТЭЗҮ болон БОНБНҮ-ний дагуу, уурхайн хаалт 2032 онд хийгдэж эхлэх тул техникийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.	1.Овоолгын талбай тэлэх үед үржил шимт хөрсийг хуулан авч нөхөн сэргээлтэд хэрэглэхээр хадгална. Хуулсан шимт хөрсийг овоолго хийж стандартын дагуу бүтцийг нь алдагдуулахгүй хадгалах арга хэмжээ авна.	га	2	0.4	0.8	2023 онд жилийн турш	Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль MNS5916:2008 MNS5917:2008
2.	Биологийн нөхөн сэргээлт:	1.Ажилчдын хотхон орчмын талбайд хөрсийг нөхөн сэргээж зүлэгжүүлж, цэцгийн мандал, мод, бут тарина.	га	1	2.0	2.0	2023 оны 5,10-р сард	Аймгийн ИТХ-ийн 2015 оны 04 сарын 56 дугаар тогтоолоор батлагдсан “1 тонн баялаг- 1 мод хөтөлбөр” MNS5917:2008
	БОНБНҮ-ний дагуу, уурхайн хаалт 2032 онд хийгдэж эхлэх тул биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.  /Иймээс дүйцүүлэн нөхөн сэргээлт хийнэ/	2.Гурвантэс сум болон БОАЖЯамнаас өгсөн чиглэлийн дагуу 2020 оны 01-р сарын 31-ний өдөр Гурвантэс сумын удирдлага болон Нарийн сухайтын бүлэг ордод үйл ажиллагаа явуулж байгаа уурхайн удирдлага, байгаль орчны мэргэжилтнүүд хуралдсан.Тус хурлын шийдвэрээр:  Нарийн сухайтын бүлэг ордод үйл ажиллагаа явуулж буй уурхайнууд хамтран сумын хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулан цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын урт хугацааны төлөвлөгөө гарган төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг жил бүр хийж ажиллана.	га	1	36.8	36.8	2023 онд	

		3. “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд гарсан бодлого шийдвэрийг дэмжин ажиллах бөгөөд тухайн бүс нутгийн онцлогт тохирсон болон зонхилогч мод, бутны үрийг түүж бэлдэх, тарих, туршилт судалгаа явуулж тарьц суулгацын нөөц бүрдүүлэх	га	1	8.0	8.0	2022 онд	“Тэрбум мод” хөтөлбөр
3.	Татан буулгах, хаалтад бэлтгэх: Уурхайн хаалт 2032 онд хийгдэнэ.	1.Хуулсан шимт хөрсийг хадгалах, төслийн үйл ажиллагаа дууссаны дараа хөрсийг бүтцийн дагуу дахин хучиж сэргээнэ. Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хадгалах бөгөөд 2 жилээс дээш хугацаагаар хадгалах тул шимт хөрсний овоолгыг 2021 онд ургамалжуулан мод тарьсан. Шимт хөрсөн дээр тарьсан модыг арчлан хамгаална.	га	1	0.2	0.2	2022 онд жилийн турш	MNS5917:2008
	Нийт					47.4		

**1. Техникийн нөхөн сэргээлт:** ТЭЗҮ болон БОНБНҮ-ний дагуу, уурхайн хаалт 2032 онд хийгдэж эхлэх тул техникийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.

**1.1** Овоолгын талбай тэлэх үед үржил шимт хөрсийг хуулан авч нөхөн сэргээлтэд хэрэглэхээр хадгална. Хуулсан шимт хөрсийг овоолго хийж стандартын дагуу бүтцийг нь алдагдуулахгүй хадгалах арга хэмжээ авна.


Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт MNS 5916:2008 стандартын дагуу ордын ТЭЗҮ болон БОНБНҮ –ний тайланд тусгаснаар үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт хамгаалалт болон хэлбэржүүлэх ажлыг хийсэн бөгөөд салхинд хийсэж чийг үржил шимээ алдахаас сэргийлж карьераас ус, мөс зөөн авчран байнгын усалж чийглэж байсан. Хүрэн толгойн уурхайн жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөнд оруулан гүйцэтгэж байна.

Хүрэн толгойн уурхайн ашиглалтын явцад  $90000\text{м}^3$  шимт хөрс хуулж хадгалж байгаа бөгөөд 2013 онд дээрх шимт хөрсний овоолгыг хэлбэржүүлэн засах ажлыг хийсэн бөгөөд 2022 онд үржил шимт хөрсийг шилжүүлэх ажлыг эхлүүлсэн. 2023 онд шинээр шимт хөрс хэлбэржүүлж овоолох талбай байгуулж хуурайшиж салхинд хийсэхээс хамгаалж дараах ажлыг зохион байгуулсан.

*2023 оны шимт хөрсний хадгалалт болон хэлбэржүүлэлт 18.2 га талбайн шимт хөрс хуулан авч,  $14800\text{м}^3$  хөрс хадгалалт болон хэлбэржүүлэлт хийсэн*



*Шимт хөрсний хадгалалт, хамгаалалт*





**2. Биологийн нөхөн сэргээлт:** ТЭЗҮ болон БОНБНҮ-ний дагуу, уурхайн хаалт 2032 онд хийгдэж эхлэх тул биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.

**2.1** Ажилчдын хотхон орчмын талбайд хөрсийг нөхөн сэргээж зүлэгжүүлж, цэцгийн мандал, мод, бут тарина.

### *Орчны тохижилт, ногоон байгууламж*

2012 онд уурхайн шинэ ажилчдын байр, оффис, нийтийн хоолны газар зэрэг барилга байгууламж ашиглалтад орсон бөгөөд эдгээр барилга байгууламж ашиглалтад орсноор ажилчдын ажиллаж, амьдрах нөхцөл сайжирч, ая тухтай орчныг нь бүрдүүлэхэд анхаарч ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажиллаж байна. 2023 оны байдлаар ажилчдын ажиллаж амьдрах тохитой орчныг бий болгох дараах бүтээлч ажлыг үргэлжлүүлэн зүлэгжүүлэх, цэцэг, мод, тарих ажлыг хийсээр байгаа бөгөөд уурхайн хотхоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хүрээнд дараах ажлыг хийсэн. Үүнд хаврын тарилтаар мод, цэцгийн мандал болон, усалгааны систем шинэчлэл засвар зэрэг ногоон байгууламжаа сайжруулах, нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна.



Орчны ногоон байгууламжийг сайжруулах ажлын хүрээнд 162 м<sup>2</sup> газрыг хагалж бэлтгэн говийн нөхцөлд ургадаг ерхөг, өлөнгө зүлэг тарьж арчлан ургуулсан. 36 м<sup>2</sup> цэцгийн мандалд цинния, бархатцы хилэн цэцгийн үрүүдийг суулган ургуулсан.

*Уурхайн хотхоны цэцэгт ургамал тарилт, хөрс бэлтгэл*




*Цэцэгт ургамал тарилт*



*Арчилгаа, цэвэрлэгээ*



*Уурхайн хотхоны тохижилт*



*Усалгааны системийг шинэчилсэн, засвар*



*2023 оны 06 сард 6,5x7,5 харьцаатай хүлэмж барьж нарын ногоо, агч-500ш жигд-500ш мод үрээр тарьж 110кг улаан лойл болон өргөст хэмх хурааж авсан.*



### Уурхайн хотхоны тохижилт царгас тарилт:

2018 оноос эхлэн царгас тарьж туршилт хийгээд байна. Царгас нь хөрсний үржил шимийг байнга дээшлүүлж байдаг. Энэ нь байгаль орчинд үзүүлж байгаа нэг чухал сайн нөлөө мөн. Сүүлийн жилүүдэд газар тариалангийн атаршуулж орхисон талбай, мөн уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн талбайг царгас тариалах замаар нөхөн сэргээдэг олон улсын туршлага юм. Царгасыг 0,6 га талбайд тариалаад 2 дахь жилээс нь эхлэн боловсорч гүйцсэн үед нь 3 удаа хурааж авсан бол 4 дахь жил буюу 2024-2023 онд 5 удаагийн ургац авч малчин иргэдэд өгч арга туршлагаасаа хуваалцаж байна. Уурхайн нөхөн сэргээлт болон гадна тохижилтод ашиглах бүрэн боломжтой ургамал гэсэн дүгнэлтэд хүрээд байна.



**2.2** Гурвантэс сум болон БОАЖЯамнаас өгсөн чиглэлийн дагуу 2020 оны 01-р сарын 31-ний өдөр Гурвантэс сумын удирдлага болон Нарийн сухайтын бүлэг ордод үйл ажиллагаа явуулж байгаа уурхайн удирдлага, байгаль орчны мэргэжилтнүүд хуралдсан. Тус хурлын шийдвэрээр:

Нарийн сухайтын бүлэг ордод үйл ажиллагаа явуулж буй уурхайнууд хамтран сумын хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулан цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын урт хугацааны төлөвлөгөө гарган төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг жил бүр хийж ажиллана. Үүний дагуу:

Нарийн Сухайтын нүүрсний бүлэг орд газарт үйл ажиллагаа явуулж буй "Монголын Алт" (Мак) ХХК, "Хүрэн толгой коал майнинг" ХХК, Өсөх зоос ХХК, "Саус гоби сэндс" ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд хамтран сумын хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулан **цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг жил бүр хийх** бөгөөд 2023 онд батлуулсан **"Байгаль орчны менежментийн төлөвлөгөө"**-т ажлыг нэгдсэн байдлаар хийж гүйцэтгэх ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 4-р багийн нутаг дэвсгэрт байрлах "Суварга"-ны эргэн тойрны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг "Эхэн гүн" ХХК-тай 2022 оны ажил гүйцэтгэх гэрээ байгуулж хамтран ажилсан. 2023 онд үргэлжлүүлэн хийхээр Нарийн сухайт бүлэг ордын 4 уурхай хамтран ажлын даалгавар боловсруулан, гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 оны 11 сарын 20-ны байдлаар ажлын гүйцэтгэл 80%-тай байна. /Хүлээж авсан акт хавсаргав/

<b>Цэцэрлэг хүрээлэнгийн бүтээн байгуулалтын ажлын даалгавар</b>				
<b>3</b>	<b>Хийгдэх ажил</b>	<b>Хэрэгжих хугацаа</b>	<b>Хэрэгжүүлэгч</b>	<b>Хамтран ажиллах байгууллага</b>
1	Цэцэрлэгт хүрээлэнгийн үүдний хэсгийн талбай тохижуулах	9-11 сар	"МАК" ХХК, "ХТКМ" ХХК, "ӨСӨХ ЗООС" ХХК, "SGS" ХХК	"ЭХЭН ГҮН" ХХК
2	Засаг дарга Б. Даваацэрэн агсны дурсгалын суварга тойрсон зам, талбайг тохижуулах			
3	Суваргатай толгойгоос зүүн талын толгойруу шилжих хэсэгт 35 метр гоёлын төмөр гүүр барих			
4	Суваргатай толгойгоос гүүр хүртэл 58 метр урт, 1,2 метр өргөн зам барих			
5	Гүүрнээс зүүн талын толгойруу гарах 40 м урт, 1,2 м өргөн зам барих			
6	Усан оргилуурын талбайг байгалийн чулуугаар хийх			
7	Нийт 700 метр зам дагуу нарны эрчим хүчээр ажилладаг 50 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах	9-11 сар		
8	Усан оргилуурын хэсэгт гоёлын гэрэлтүүлэг хийх			
9	Гүүрний дагуу гэрэлтүүлэг угсрах			
10	Модон сүүдрэвч 2 ширхгийг байршуулах			
11	Зам талбайд 10 ширхэг сандал байршуулах			
12	Сандал бүрийн хажууд хогийн сав байршуулах			

### Гурвантэс сумын цэцэрлэгт хүрээлэнгийн ажлын явцын зураг болон товч тайлан

Манай компани нь цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт хийх ажлыг гэрээний дагуу хийж гүйцэтгэж байна. 2023 оны 11 сарын 20 өдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

#### *Ажлын явц*



#### *Уурхайн төлөөлөл ажлын явцтай танилцав*



2.3 “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрэн гарсан бодлого шийдвэрийг дэмжин ажиллах бөгөөд тухайн бүс нутгийн онцлогт тохирсон болон зонхилогч мод, бутны үрийг түүж бэлтгэх, тарих, туршилт судалгаа явуулж тарьц суулгацын нөөц бүрдүүлэх.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьц суулгац бэлтгэж буй аж ахуйн нэгж, иргэдтэй уулзах мөн тухайн бүс нутагт мод заг тарих боломжит газруудтай танилцсан ажлын тайлан


2023.02.15

Гурвантэс сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн байгаль орчны мэргэжилтнүүдийг мод үржүүлгийн ажил хувиараа хийж байгаа аж ахуй нэгж, иргэдтэй уулзуулан туршлага солилцох ажлыг 2023 оны 02 сарын 14-ны өдөр ЗДТГ-аас зохион байгуулав.

Хамтран ажилласан хүмүүс:

- А.Атар - Гурвантэс сумын Байгаль орчны улсын хяналтын байцаагч
- А.Бүжин - Уул уурхай, ус хариуцсан мэргэжилтэн
- ЗДТГ-ын хөдөө аж ахуйн мэргэжилтэн-2
- Орон нутгийн нийт 2 иргэн
- SGS ХХК, МАК-Нарийн сухайтын уурхай, Өсөх Зоос ХХК, Бласт ХХК -ийн байгаль орчны мэргэжилтнүүд
- МАК ХХК-ий Нарийн сухайтын уурхайн байгаль орчны мэргэжилтнүүд тус тус оролцов.

#### Газрын маршрут





### 1. Загийн тарьц – загаар ойжуулах ажил хийгдэж буй талбай

Загийн ойн зурвас үүсгэх зорилгоор орон нутгийн хөгжлийн төсвөөр 10 га талбайг худалдан авсан бөгөөд сумын төвөөс 25 км. 2022 оны хавраас эхлэн үрээр бортогонд тарилт хийж, тус оны намар үржүүлгийн талбайн 1,8 га талбайд шилжүүлэн суулгаж, үржүүлгийн ажлыг хийж байна.

*Нэг болон түүнээс дээш настай загийн тарьц, суулгацууд*



### 2. Зүүн, Дунд, Баруун гол – Заг тарихаар төлөвлөсөн газрууд

Гурвантэс сумын бэлчээрийн нийт нутаг дэвсгэрийн 634,842.9 га буюу 22.7% -г , ойн нөөцийн 89% -г тус тус заг эзэлдэг. Иймд тухайн бүс нутагт тарималжин ургаж, нөөцийг хамгаалах боломжтой мод нь заг бөгөөд орон нутгаас Зүүн, Дунд, Баруун голын элсэрхэг хөрстэй хөрсийг сонгон авч тарималжуулахаар ажиллаж байна. Тус газрууд нь сумын төвөөс 50 км зайтай заган ойт газар байв.

### 3. Индэрт – Үрсэлгээ бэлтгэх сонирхолтой өрх

Өмнөговь аймгийн ЗДТГ-с “Нутгийн хишиг 2024”, Бэлчээр усжуулалтын II аяны хүрээнд Баясах багийн “Индэрт” инженерийн хийцтэй худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийг 17.500.000 сая төгрөгөөр суурилуулж, үүнийгээ түшиглэн малчин иргэд цэцэрлэгт хүрээлэн байгуулж 5 төрлийн (хармаг, заг, хайлаас, бүйлс, жигд) модыг үрээр болон суулгацаар тарьж арчилж байна. Сумын төвөөс 80 км зайд оршдог.

*Индэрт нутгийн иргэдийн мод тарьж байгаа талбай*



4. Хонингийн булаг – Гадаргын ус бүхий газар

Сумын төвөөс 90 км зайд оршдог бөгөөд гадаргын ус их хэмжээгээр хуримтлагдсан элсэрхэг, зөөлөн хөрстэй газар байв. Сумын ЗДТГ-с тус нутгийг хашиж хамгаалан, заган ойн үржүүлэг хийлгэхээр Баатарван ХХК-д санал хүргүүлэн хамгаалахаар төлөвлөгдөн ажиллаж байна.

*Хонингийн булаг*



Мөн тус сумын нутаг дэвсгэрт Давсны орд бүхий газар байдаг бөгөөд нутгийн иргэд давс ургах үеэр хэрэглээний давсыг түүж авч, худалдан борлуулдаг байна.

2.3.1 "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд модны үрийн санг бүрдүүлэх, бүс нутгийн онцлогт тохирсон мод бутыг кемпийн мод үржүүлгийн талбайд тарих ажлыг 2022 онд эхлүүлж заг, хайлаас, агч, жигд модыг үрээр үржүүлэх модны нөөц бүрдүүлэн ажиллаж байна.

Уурхайн мод үржүүлгийн талбайд ургаж буй мод бутыг шилжүүлэн суулгах ажлын хүрээнд:

- Бласт Агч 70 ш
- Бласт Сухай 222 ш
- Бласт Жигд 306 ш
- МАК Нарийн сухайтын уурхай Сухай 400 ш
- МАК Нарийн сухайтын уурхай Агч 23 ш
- Кемпийн хойд талбайд Сухай 240 ш
- Кемпийн хойд талбайд Заг 20ш
- Кемпийн хойд талбайд Жигд 173 ш
- Бага-Овоо багийн төв Сухай 240 ш
- Бага-Овоо багийн төв Жигд 173 ш
- Малчин иргэд Жигд 50 ш

Хаврын тарилгаар нийт **1917ш** мод бут шилжүүлэн суулгаад байна.

*"Бласт" ХХК-д агч, сухай, жигд мод өгсөн байдал*



*"Монголын Алт" (Мак) ХХК Нарийн сухайтын уурхай агч, сухай, жигд мод өгсөн байдал*



*Кемтийн хойд талбайд агч, сухай, жигд мод тарилт*



*Мод тарилт болон бэлтгэл ажил*



*Мод ухаж авах, тээвэрлэлт*



*Усалгаа арчилгаа*



Гурвантэс сумын Бага-Овоо багийн төв рүү шилжүүлэн суулгах ажлыг багийн дарга болон нутгийн иргэдтэй хамтран зохион байгуулсан.

*Мод тарих бэлтгэл ажил*



*Мод тарилт*



*Усалгаа арчилгаа*



*Тарьсан мод хамгаалах 160м урт төмөр торон хашаажуулалд хийсэн*



### 2.3.2 “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд модны үр түүж бэлтгэх ажил.

*Хайлаас, агч, жигд, заг модны үр түүж бэлтгэх ажил 20кг*



*Заг модны үр бэлтгэл*



### 2.3.3 “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд модыг үрээр тарих талбайг бэлтгэж тарих.

Ажилчдын байрны мод ургасан талбайгаас агч, хайлаас, жигд модны үрийг түүж 2022 онд 2000м<sup>2</sup> талбайг бэлтгэж үрээр тарьсан. 2023 онд агч, хайлаас, жигд модны үрийг түүж 600м<sup>2</sup> талбайд нөхөн тарилт болон хүлэмжид үрээр тарьсан.

#### *Хөрс бэлтгэл*



#### *Хайлаас, агч, заг мод үр гадаа талбай болон хүлэмжид тарилт*



#### *Усалгаа арчилгаа /өглөө оройн усалгаа/*



*Хайлаас, агч, заг, жигд мод үрээр тарилт, ургасан байдал*



*Хайлаас 25-94см, жигд 12-20см, агч 8-19см өндөр ургасан байна.*





МАК Нарийн сухайтын уурхайтай хамтран Батлагдсан хуваарийн дагуу Баруун сухантын амрах талбайн ногоон байгууламжийн усалгааг 14 хоногт нэг удаа усалгаа арчилгаа хийж байна.

*Мод услах үеийн зураг*



2023 оны 11 сарын 04 нд намрын мод тарилтын хүрээнд ажилчдын хотхонд байгуулсан мод үржүүлгийн талбайгаас 30 ширхэг хайлаас модыг захиргаа, санхүүгийн хэсэгтэй хамтран 8 хүний бүрэлдэхүүнтэй Баруун сухантад шилжүүлэн суулгаж намрын цэнэг усалгааг хийсэн.

*Баруун сухантад намрын мод тарилт хийх явц*



### 3. Татан буулгах, хаалтад бэлтгэх: Уурхайн хаалт 2032 онд хийгдэнэ.

3.1 Хуулсан шимт хөрсийг хадгалах, төслийн үйл ажиллагаа дууссаны дараа хөрсийг бүтцийн дагуу дахин хучиж сэргээнэ.

Шимт хөрсний овоолгыг 2 жилээс дээш хугацаагаар хадгалах тул шимт хөрсний овоолгыг ургамалжуулан мод тарьсан. Шимт хөрсөн дээр тарьсан модыг арчлан хамгаална.

*Хүрэн толгой уурхай шимт хөрсний 3 овоолго үүсгэж 34936 м<sup>2</sup> талбайд, 47825 м<sup>3</sup> хөрс хадгалалт болон хэлбэржүүлэлт хийсэн*



*Шимт хөрсний хадгалалт, хамгаалалт сухай ургасан байдал*



*2023 оны шимт хөрс хуулан авалт*



#### 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Зорилго:** Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийн 8.4.6. заалтын дагуу Нарийн сухайтын уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад учруулж байгаа байгаль орчны сөрөг нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулах

2017 онд “Чандлан” ХХК-иар тус ажлыг гүйцэтгүүлж “Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний судалгааны тайлан” – г Өмнөговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт болон Гурвантэс сумын ЗДТГазарт хүргүүлж, танилцуулсан. 2019 онд “GREEN TRENDS” ХХК-тай гэрээ байгуулж “Хөхөлзөхийн говь”-д судалгааны ажил хийлгэсэн. Судалгааны ажлын тайлан 2020 онд хүлээн авсан бөгөөд тайланд тусгагдсан зөвлөмж, төлөвлөгөөг баримтлан ажилласан.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Тухайн сонгон авсан талбайд амьтдын амьдрах орчинг сайжруулах	1.Уурхайн ойр орчмын ургамал, харсүүлт түүний амьдрах орчин бусад зүйлийн амьтдын тоо толгойн мониторинг судалгаа хийж бүртгэж байх. 2.Талын пост хэмээх газар зэрлэг ан амьтанд зориулсан инженерийн хийц бүхий уст цэг 2021 онд байгуулсан түүний хэвийн ажиллагаа болон зэрлэг амьтад ундалж байгаа зэрэгт хараа хяналт тавих. 3.Төсөл хэрэгжих хугацаанд сонгон авсан талбайд ган, зуд ихтэй жилүүдэд зэрлэг ан амьтдын идэш тэжээлийг бэлдэх биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Хөхөлзөхийн говь, Хөхөлзөхийн Сархиа 3080 га талбайд, Уурхай орчимд	2 3 3	0.6 0.4 3.0	1.2 1.2 9.0	2023 онд 2023 онд 2023 онд	БОННУ-ний аргачлал, Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын судалгааны үр дүн

2.	Байгаль орчныг хамгаалах	1.Байгаль орчны чиглэлээр Дэлхийн тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан Байгаль хамгаалах иргэд, нөхөрлөлүүд, сурагчдын клубийг дэмжиж хамтран ажиллана.	Гурвантэс сум	2	3.0	6.0	2023 онд	Байгаль орчны тэмдэглэлт өдөр
		2.Булгийн эхийг сэргээх зураг төсөл гаргах		1	1.0	1.0	2023 онд	
		3.Улсын их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээг зохион байгуулахад Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран ажиллана.	Өмнөговь аймаг	5 га	2.36	11.8	2023 онд	Техникийн нөхөн сэргээлт
Нийт зардал						30.2		

**1.1** Уурхайн ойр орчмын ургамал, харсүүлт түүний амьдрах орчин бусад зүйлийн амьтдын тоо толгойн мониторинг судалгаа хийж бүртгэж байх.

### I улирлын амьтны хамтарсан судалгааны тайлан

Судалгаа хийсэн хугацаа: 2023.01.17-ны өдөр 09-18 цагийн хооронд

Судалгаа хийсэн байршил: Уурхайн эргэн тойрны 20км-ын радиуст

Судалгаа хийсэн: МАК Нарийн сухайт уурхай болон “Хүрэн толгой коал майнинг” ХХК, “Саусгоби Сэндс” ХХК-ын байгаль орчны мэргэжилтэн нар

Судалгааны үр дүн: 13 байршилд нийт 51 тоо толгой хар сүүлт зээр, 3 аргал тааралдсан. Хар сүүлт зээрийн сүргийн бүтэц нь:

- Уурхайн арын уулсаар 2-оос 4 тоогоор
- Уурхайн урдуур буюу ухаа гүвээгээр 4-өөс 6 тоогоор
- Уурхайн орчимд 4-5 тоогоор
- Уурхайн урдуур буюу өргөн сайр хөндийгөөр 10-27 тоогоор буюу сүрэглэн бэлчээрлэж байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу уурхайн дэд бүтцийн хөгжил, тэлэлт, тухайн бүс нутагт эдийн засгийн өргөн боломжид тулгуурлан ирэх иргэдийн шилжилт, суурьшилт нэмэгдсэнээс үүдэлтэй ан амьтан болон ургамлын тоо толгойг бүртгэх судлах ажлыг уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай хамтран улирал тутамд мониторинг хийж байхаар төлөвлөн ажилладаг. Иймд тус мониторинг ажиглалт хийж, цэг хооронд, судалгааны ажлыг гүйцэтгэж, амьтан харагдах байдлын мэдээллийг нэгтгэн оруулав.

Хүснэгт 1. Судалгааны үед тааралдсан амьтны байршил, тоо толгой

№	Координат		Тоо	Зүйлийн нэр	Газрын нэр	Ургамалжилт
	N	E				
1	43°06'51.72	101°04'28.49	4	Хар сүүлт	Хайлаастын хавцал	Харгана-баглуур-хялганат бүлгэмдэл
			1	Тас шувуу		
2	43°07'58.07	101°05'31.75	2	Хар сүүлт	Уурхайн карьер	Харгана-баглуур-хялганат бүлгэмдэл
3	43°08'46.64	108°39'53.00	9	Хар сүүлт	Уул, толгод	Харгана-баглуур-хялганат бүлгэмдэл
4	43°09'14.68	101°07'24.87	3	Аргал	Ямаат	Харгана-баглуур-хялганат бүлгэмдэл
			2	Хар сүүлт		
5	43°04'59.92	101°13'10.96	2	Хар сүүлт	Задгай устай	Ногоон чулууны булаг
6	43°02'41.14	101°18'52.25	8	Хар сүүлт	Уул, толгод	харгана-баглуур-хялганат бүлгэмдэл
7	42°57'12.97	101°25'55.21	1	Хар сүүлт	Ухаа бүвээ	Баглуурт-бударга-хотирт
8	42°55'42.66	101°25'01.30	3	Хар сүүлт	Шивээгийн застав	Баглуурт-бударга-хотирт
9	42°56'46.83	101°23'03.53	2	Хар сүүлт	Нүүрс тээврийн	Зээргэнэ-баглуур-шавагт бүлгэмдэлтэй

					замаас зүүн тийш	
10	42°57`12.47	101°21`41.78	2	Хар сүүлт	Сайр	Зээргэнэ-баглуур-бударганат бүлгэмдэлтэй сайр
11	42°93`14.53	101°20`36.15	1	Хар сүүлт	Нүдэн булаг	Баглуур-шарилж-хотирт
12	42°56`49.30	101°05`34.84	1	Хар сүүлт	Уст цэг	Хотир-хармаг-бударганат
13	42°09`44.24	101°05`36.78	7	Хар сүүлт	Өсөх зоос баруун тал	Хотирг-бударганат
Хар сүүлт			45			
Аргал			3			
Тас			1			

Дүгнэлт: Амьтан тааралдсан байршлуудыг газрын гадаргын төлөв байдлаар нь уурхайн орчим, уурхайн арын уулс, уурхайн урдуур гэж хуваасан. Тус газруудаар явахад нийт 45 хар сүүлт, 3 аргал, 1 тас, нийт 49 бодгаль ажиглагдсан байна. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нийт газар нутагт өвс тэжээл дутмаг байдал үүсэж зэрлэг ан амьтан, бэлчээр дагаж шилжин тоо толгой цөөрөх тохиолдол их байна.

Хамтарсан судалгааг үргэлжлүүлэн төлөвлөгөөтэй, давтамжтай хээрийн судалгааг гүйцэтгэж мөн судалгаа явуулсан байршлуудын хамгийн их бодгаль бүртгэгдсэн газруудад биотехникийн арга хэмжээ авч ан амьтны тоо толгойг дахин бүртгэж цаашдын хамгааллын үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Хайлаастын хавцлын орчим



Хайлаастын хавцал орчим



➤ Уурхайн урдуур: Өргөн том сайруудаар Хар сүүлт олон тоогоор сүрэглэсэн. Задгай уст цэг ихтэй боловч бэлчээрийн ургамалжилт муутай тул амьтны идэш тэжээлийн хомсдолтой байна.



Биотехникийн арга хэмжээ авах санал:

1. Ямаатын аманд бэлчээрийн гарц муу байгаа учир өвс тэжээл тавих.
2. Задгай ус болон цастай байгаа учир мөс тавих шаардлагагүй байна.

Судалгааны үед тааралдсан амьтны байршил




## II улирлын амьтны хамтарсан судалгааны тайлан

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн Нарийн Сухайтын” нүүрсний уурхай нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Урт багийн нутагт байрлах бөгөөд 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу уухайн орчмын зэрлэг амьтны тандалт судалгааг Хүрэнтолгой коал майнинг ХХК-тай хамтран 6-р сарын 5-ны өдөр хийж гүйцэтгэв.

**Бүс нутгын онцлог:** Өмнөговь аймаг Гурван тэс сумын Бага Овоо багт байрлаж байна гэж үзвэл, Бага-Овоо баг нь 276264.5776 га нутаг дэвсрэгтэй нутаг дэвсгэр баруун, баруун урд талаараа Тост баг, хойд талаараа Урт баг, зүүн, зүүн хойт талаараа Баясах баг, өмнөд хэсгээрээ БНХАУ-ын ШУӨЗО-ны Альша аймгийн Эзний хошуутай зах нийлэн хиллэдэг. Монгол-Алтайн нурууны цөлөрхөг бүсэд оршдог. байгалийн үзэсгэлэнт газар ихтэй, Хөгшөө, Шугшаа, Суварга, Товон, Буурал, Их бага Баян, Сүмбэн, Тахилгат, Хайлаастын өндөр уулс, Хайлаастын хөндий, Шатын ам, Хуршуутын гол, Зүүн, баруун сухантын гол горхиуд нь Жигд, Хайлаас, Тоорой, Заган ой бүхий баян бүрдүүдтэй. Баянгийн болон Хайрт рашаан уснаас гадна хармаг, лидэр, чихэр өвс улаан, цагаан гоёо, таван салаа, хурдан цагаан, бажууна, эмт өвс зэрэг эмийн ургамлууд ургадаг. **Аргаль, янгир, хар сүүлт, ирвэс, чоно, мануул, үнэг, шилүүс,** зэрэг ан амьтад, олон төрлийн жигүүртэн шувууд амьдардаг. Цаашид аялал жуулчлал хөгжих бүрэн боломжтой газар нутагтай. Үүнээс сумын Есөн гайхамшигт Хайлаастын хөндий багтдаг гэж судлагдсан бол одоо Байгаль талаас нь илүү мэдээлэл цуглуулах хэрэгтэй жишээлбэл: Бага овоо багт 3 орон нутгын тусгай хамгаалалттай газар нутаг байдаг бөгөөд, Хайлаастын хөндийн, Овоот бага хурал, Хайрт рашаан гэсэн Орон нутгын тусгай хамгаалалтанд авсан газар байдаг бөгөөд энэ газрын байгалийн онцолгыг судлах.

### Амьтны мониторингийн цэг





**Зэрлэг амьтдын мэдээлэл:** Аргаль, янгир, хар сүүлт, ирвэс, чоно, мануул, үнэг, шилүүс, байдаг бөгөөд дээр амьтад Улаан дансанд бүртгэлтэй амьтад юм.

Нарийн сухайтын уурхай орчим нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Бага Овоот багийн нутаг, Монгол орны байгалийн бүс бүслүүрийн хувьд цөлийн бүсэд хамаарна.

Судалгааны ажлын төлөвлөгөө:

1. Судалгааны цэгүүдэд орчны хэмжилт хийх
2. Ажиглалтын цэгүүдэд ажиглалт хийх, амьтны тохиолдцыг гэрэл зураг болон солбицлын цэгээр баталгаажуулж бүртгэх.
3. Бүртгэсэн амьтдыг төрөл зүйл болон нас хүйсийн бүтцийг тодорхойлох.
4. Уурхай орчмын төлөвлөсөн маршрутын дагуу баянбүрд болон уст цэгүүд дээр ажиглалт хийж зүйлийн бүртгэл хөтлөх.

**Судалгааны цэг сонгох:** Амьтны аймгийн мониторингийн цэгийг дараах мэдээллүүдийг ашиглан газар зүйн мэдээллийн системийн өгөгдлүүдийг Google Earth программ дээр давхцуулан боломжит цэгийг сонгосон. Үүнд:

- Задгай уст цэгийн байршил (Монгол орны уст цэгийн байршлын тоон мэдээлэл)
- Амьтан идээшлэх газрын гадарга, хэв шинж ургамалжилт (Ургамалжилтын зураг)
- Мэргэжлийн байгууллагуудын хийсэн судалгаа шинжилгээний ажлуудад тусгагдсан мэдээлэл (БОННУ, Газрын хянан баталгаа, 2016 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн тайлан)
- Бусад хэмжилт судалгаагаар явж байх үед амьтан тогтмол тааралддаг газрууд.

№	Байршил	Солбицол		Тайлбар
		Өргөрөг	Уртгаг	
А-1	Хотхоны баруун талын тогтсон ус	43° 2'24.74"	101° 13'54.02"	Тогтсон усанд шувууд цуглардаг
А-2	Энгэрийн дэрсний булгийн зүүн талын толгой	43° 3'38.78"	101° 15'5.81"	Задгай уст цэгийн ойролцоо
А-3	Сайрын бут сөөгт бэлчээр	43° 3'23.19"	101° 6'47.98"	Амьтан идээшихэд тохиромжтой бэлчээр
А-4	Тэгш тал хөндийн бут сөөгт бэлчээр	43° 1'53.11"	101° 2'58.47"	
А-5	Хайлаастын хавцалын ойролцоо	43° 4'21.29"	101° 0'9.44"	Бут сөөг оролцсон хялгана баглуурт хөндий
А-6	Хуршуут булгийн ойролцоо	43° 1'52.86"	100° 59'48.29"	Задгай уст цэгийн ойролцоо
А-7	Эхэн уст булгийн ойролцоо	42° 59'49.34"	100° 58'3.46"	Задгай уст цэгийн ойролцоо
А-8	Баглуур хялганат бэлчээр	42° 59'28.71"	101° 2'44.14"	Мэргэжлийн байгууллагын хийсэн судалгаанд амьтан их тааралдсан газар
А-9	Аараг толгодын бэлчээр	42° 54'37.23"	101° 4'40.70"	
А-10	Өнчин толгой	42° 57'45.13"	101° 11'52.78"	

**Мониторинг хийх аргачлал:** Сонгосон цэгүүдэд улирал тутамд нэг удаа тогтсон цэгт ажиглалт хийж, цэг хооронд Zig Zag замналаар нийт 112 км явж тааралдсан амьтдын тоо толгой, сүргийн бүтэц, фото зургийг авч, байршлыг тэмдэглэж үр дүнг нэгтгэн боловсруулна.


**Судалгаанд ашиглах багаж хэрэгсэл:** Амьтны мониторингийн судалгаанд дараах багаж хэрэгсэл ашиглана.

№	Багаж хэрэгсэл	Тайлбар	Гарах үр дүн
1	Дуран	Амьтан ажиглах цэгийн эргэн тойронд ажиглалт хийх	Цэгийн эргэн тойрныг ойртуулан татаж харах
2	Зургийн аппарат	Тааралдсан амьтны фото зургийг авах	Фото зургийг авч баримтжуулах, мэдээллийн сантай болох
3	Байршил тогтоогч систем (GPS)	Амьтны цэгийн байршлыг тогтоох	Газарзүйн мэдээллийн системийн программ ашиглан тархалтын зураг гаргах

Хүснэгт 1. Судалгааны үед тааралдсан амьтны байршил, тоо толгой

№	Координат		Тоо	Зүйлийн нэр	Газрын нэр	Ургамалжилт
	N	E				
1	43°06'51.72	101°04'28.49	4	Хар сүүлт	Хайлаастын хавцал	Харгана-баглуур-хялганат бүлгэмдэл
			1	Тас шувуу		
2	43°07'58.07	101°05'31.75	2	Хар сүүлт	Уурхайн карьер	Харгана-баглуур-хялганат бүлгэмдэл
3	43°08'46.64	108°39'53.00	9	Хар сүүлт	Уул, толгод	Харгана-баглуур-хялганат бүлгэмдэл
4	43°09'14.68	101°07'24.87	2	Хар сүүлт	Ямаат	Харгана-баглуур-хялганат бүлгэмдэл
5	43°04'59.92	101°13'10.96	2	Хар сүүлт	Задгай устай	Ногоон чулууны булаг
6	43°02'41.14	101°18'52.25	8	Хар сүүлт	Уул, толгод	харгана-баглуур-хялганат бүлгэмдэл
7	42°57'12.97	101°25'55.21	1	Хон хэрээ	Ухаа бүвээ	Баглуурт-бударгахотирт
8	42°55'42.66	101°25'01.30	3	Хар сүүлт	Шивээгийн застаав	Баглуурт-бударгахотирт
Хар сүүлт			30			
Хон хэрээ			1			
Тас			1			

Ажиглалтын үед авсан гэрэл зургууд



### Ш улирлын амьтны хамтарсан судалгааны тайлан

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу уурхайн дэд бүтцийн хөгжил, тэлэлт, тухайн бүс нутагт эдийн засгийн өргөн боломжид тулгуурлан ирэх иргэдийн шилжилт, суурьшилт нэмэгдсэнээс үүдэлтэй ан амьтан болон ургамлын тоо толгойг бүртгэх судлах ажлыг уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай хамтран улирал тутамд мониторинг хийж байхаар төлөвлөн ажилладаг. Иймд тус мониторингийн 2 улирлын судалгааг 2023 оны 07 дугаар сарын 15-ны өдөр ажиглалт хийж, цэг хооронд, мониторингийн ажлыг гүйцэтгэж, амьтан харагдах байдлын мэдээллийг нэгтгэн оруулав.

#### Судалгааны ажилд шаардлагатай тоног төхөөрөмжүүд

№	Хэмжилт хийсэн төрөл	Хэмжилт хийсэн багаж, нэр	Хэмжилт хийсэн багаж
1	Гадаад орчны хэмжилт	Салхины хурд	Environmental-meter
2		Орчны гэрэлтүүлэг	
3		Агаарын дундаж чийгшил	
4		Дуу чимээ	
5		Температур	
8	хөрс	Температур	Soil survey instrument
9		РН	
10	Амьтаны тоо толгойн бүртгэл	1, нүдний дуран 2, Байршил тогтоогч gps3, Замналын судалгааны нэгдсэн хүснэгт	



### Судалгааны тоон үзүүлэлтүүд

1. Гадаад орчны хэмжилт:

№	Байршил	Гадаад орчны үзүүлэлтүүд					Температур, °C
		Салхины дундаж хурд м/сек	Орчны гэрэлтүүлэг, LUX	Чийгшил, %	Гадаад орчны дуу чимээ, dB		
					бага	их	
1	Баруун сухант	6	1902	24.5	41.7	67.2	25
2	Нүдэн булаг	1.2	1945	23.8	42.1	67.4	28
3	Их хонгил	6.5	1958	20.2	43.5	71.4	31.2
4	Ямаат уул	4.8	1870	18.2	44.1	69.4	26.4

Хэмжилт хийж байгаа зураг



2. Амьтан тааралдсан байдал:

Уг судалгаагаар нийт нүүдлын болон суурин шувуу, 1 зүйлийн хөхтөн амьтан харж тэмдэглэсэн.

№	Монгол нэр	Газрын нэр	Газар зүйн байршил	Тоо хэмжээ	Нийт
1	Хондон ангир	Баруун сухант	47T0688405 4761119	6	6
5	Хар сүүлт зээр	Баруун сухант орох замд	47T0688354 4761252	2	31
6		Морин зам орчим	47T0679333 4755496	8	
7		Нүдэн булаг орчим	47T0670001 4757584	3	
8		Өсөх зоосын баруун талд	47T0668917 4804134	8	
9		Их хонгил	47T0672373 4113335	5	
10		Сумын хойно	470667312 4799181	2	
11		Ямаат уул	47T0668557 4816447	3	
НИЙТ ДҮН					37

Амьтны мониторингийг уурхайн орчимд Баруун сухант, Морин зам, Их хонгил, Нүдэн булаг, Ямаат уул, Уст цэгүүд, уурхайн баруун тал, Ногоон чулууны булаг орчим гэсэн газруудад нийт 225 км явж гүйцэтгэсэн. Тус газруудаар явахад нийт 31 хар сүүлт, 6 хондон ангир нийт 37 бодгаль ажиглагдсан байна. Бүртгэгдсэн хар сүүлтийг нас хүйсээр нь задалж үзвэл эр 7, эм 11, төл 2, тодорхойгүй 10 байна. Баруун сухантын хөв цөөрмийн усанд 2 ангир 4 дэгдээхэйн хамт өндөглөн зусаж байна. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын газар нутагт хэт хуурайшилт ихтэй байгаа учир Өвс тэжээлийн дутмаг байдал үүсэж зэрлэг ан амьтан, бэлчээр дагаж шилжин нүүдэллэх тоо толгой цөөрөх тохиолдол их байна. Тоологдсон амьтдын дунд энэ жилийн шинэ төл бага байгаа нь өвс ургамал муутай ган зудтай байсантай холбоотой.

Хамтарсан судалгааг үргэлжлүүлэн төлөвлөгөөтэй, давтамжтай хээрийн судалгааг гүйцэтгэж ан амьтны тоо толгойг дахин бүртгэлжүүлж цаашдын хамгааллын үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.



*Баруун сухантын хөв цөөрөм*



*Хайлаастын хавцал*



*Их хонгил*



*Ямаат уул*



**1.2.**Талын пост хэмээх газар зэрлэг ан амьтанд зориулсан инженерийн хийц бүхий уст цэг 2021 онд байгуулсан түүний хэвийн ажиллагаа болон зэрлэг амьтад ундалж байгаа зэрэгт хараа хяналт тавих

Талын пост хэмээх газар зэрлэг ан амьтанд зориулсан инженерийн хийц бүхий уст цэг байгуулах ажил 2021 онд эхлүүлсэн.

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Нарийн сухайтын нүүрсний ордын дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд:

Зэрлэг ан амьтанд зориулсан уст цэг байгуулах ажлыг 2022 оны 6-р сард “ЦМ ундарга” ХХК-ийн 7 хүнтэй баг ирж тус ажлыг хийж гүйцэтгэсэн. Байгаль орны инженер хяналт тавьж, хилийн цэргийн 0166-р анги хамтарч ажилласан.

2023 онд улирал бүр зэрлэг ан амьтанд зориулсан уст цэгийн үйл ажиллагааг шалган ус гаргах насос эвдрэл гарсныг засварлан хэвийн ажиллагаанд оруулсан, нарны самбар дээрх шувууны цангис, баасыг цэвэрлэн шувуу үргээгч хийж гүйцэтгэж өвс тэжээл 10 боодлыг тавьсан. Хяналтын камерыг шалган дүрс бичлэгийг архивлан ажилласан.

#### *Худгийн засвар сайжруулалт*



**1.3.** Төсөл хэрэгжих хугацаанд сонгон авсан талбайд ган, зуд ихтэй жилүүдэд зэрлэг ан амьтдын идэш тэжээлийг бэлдэх биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

**1.3.1.** 2023 оны 01 сарын 21-нд МАК нарийн сухайтын уурхай хамтран ТТБН-ны байгалийн нөөц газарт хамрагдах Тэхтийн хөв хэсэгт ажиллаж янгир ямаа, аргаль зэрэг зэрлэг амьтны амьдрах орчныг сайжруулах идэш тэжээлийг нэмэгдүүлэх зорилгоор 50ш боодол өвс, тэжээл зэрлэг амьтдын уст цэг болох хадан хавцлын тогоонд зөөвөрлөн хийж биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

Цаашид биотехникийн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу шат дараатай авч хэрэгжүүлсэн.

*Ажил эхлэхийн өмнө*



*Ажлын явц*



**1.3.2.** 2023 оны 02 сарын 25-нд МАК-Нарийн сухайтын уурхайтай хамтран ТТБН-ны байгалийн нөөц газарт хамрагдах “Ямаат уул” хэсэгт ажиллаж янгир ямаа, аргаль зэрэг зэрлэг амьтны амьдрах орчныг сайжруулах идэш тэжээлийг нэмэгдүүлэх зорилгоор 15ш боодол өвс, тэжээл зэрлэг амьтдын уст цэг болох хадан хавцлын тогоонд зөөвөрлөн хийж биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

*Ажил эхлэхийн өмнө /Ямаат уул/*



*Ажлын явц*

**1.3.3.** 2023 оны 09 сарын 07-нд “Саусгоби сэнде” ХХК, “Монголын Алт МАК” ХХК-ийн Нарийн сухайт уурхайн байгаль орчны мэргэжилтэн нар хамтран 2 тонн усыг Хайлаастын хавцал гэх газарт байрлуулан тавьж биотехникийн арга хэмжээг зохион байгуулсан.



**1.3.4.** 2023 оны 11 сарын 12-нд биотехникийн ажлыг “Хайлаастын хавцал” д МАК-Нарийн сухайтын уурхайн байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулсан. Тус биотехникийн ажлын хүрээнд: 17 боодол өвс 8 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.





**2.1. Байгаль орчны чиглэлээр Дэлхийн тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан Байгаль хамгаалах иргэд, нөхөрлөлүүд, сурагчдын клубийг дэмжиж хамтран ажиллана.**

### **2.1.1. Байгаль орчны өдрүүдийг тохиолдуулан зохион байгуулсан тэмцээний тайлан**

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан байгаль хамгаалах иргэд, нөхөрлөлүүд, сурагчдын клубийг дэмжиж хамтран ажиллах арга хэмжээг төлөвлөсөн. Дээрх ажлын дагуу сурагчдын байгаль хамгаалах, экологийн боловсрол хандлагыг сайжруулах зорилгоор “Хүрэн толгой коал майнинг” ХХК, “МАК-Нарийн сухайт”-н уурхай хамтран 1.1 сая.төг төсөвтэй дараах тэмцээнүүдийг зохион байгууллаа.

- Дэлхийн усны өдрийг тохиолдуулан I-V ангийн дунд “Ус ба амьдрал” сэдэвт гар зураг (poster) шалгаруулах уралдаан
- “Эх дэлхийн цаг” олон улсын арга хэмжээг тохиолдуулан VI-XII ангийн дунд “Хаягдал зай (баттерей)” цуглуулах сав шалгаруулах уралдаан

Зохион байгуулалт:

- Бүтээлийг Гурвантэс сумын ЕБС багш, нийгмийн ажилтнууд хүлээн авсан. 2023.3.18-23нд
- Шалгарсан бүтээлүүдийг 2023 оны 3 сарын 23 ны өдөр эцсийн байдлаар зарлаж шагнал урамшууллыг гардуулсан.

Үр дүн:

- 2023 оны Байгаль орчныг хамгаалах биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлын талаар нийт иргэдэд таниулсан.
- Хог хаягдлыг дахин боловсруулах ач холбогдлыг тэмцээнд шалгарсан бүтээлүүдээр дамжуулан иргэд, компанийн ажилчдад таниулж хэрэглээнд нэвтрүүлнэ.
- Байгаль орчны өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг жил бүр уламжлал болгон хэвшүүлэх зэрэг ач холбогдолтой.

Шагнал урамшуулал:

*Тэмцээний шагналт байранд шалгарсан багш сурагчид*





*Тусгай байрын шагналт сурагчид*

№	Ус ба амьдрал сэдэвт гар зургийн уралдаан I-V анги	Хаягдал зай хураагуур цуглуулах хайрцаг бүтээх уралдаан VI-XII анги
<b>I байр</b>	Шагналт байранд шалгарсан сурагчдыг “Хүрэн толгой коал майнинг”ХХК болон Монголын Алт (МАК) ХХК-ийн нүүрсний уурхайтай танилцуулан мөн Гурван тэс сумын байгалийн цогцолборт газруудаар нэг өдрийн аялах эрхээр шагнасан.	
<b>II байр</b>		
<b>III байр</b>		
<b>Тусгай байр</b>	<p><b>I-V анги “Ус ба амьдрал” гар зургийн уралдаан</b></p> <p>1-р байр 5б ангийн сурагч Б.Ухаанзаяа</p> <p>2-р байр 1б ангийн сурагч З.Энэрэл</p> <p>3-р байр 5а ангийн сурагч Ш.Цэлмэг</p> <p>Тусгай байранд шалгарсан сурагчид:</p> <p>1г ангийн сурагч М.Гэгээнэ</p> <p>4г ангийн сурагч Жамъяанмядаг</p> <p>5а ангийн сурагч Б.Азбилэг</p> <p>3б ангийн сурагч О.Сондор</p> <p>2г ангийн сурагч Б.Аминцэцэг</p> <p><b>VI-XII анги “Хаягдал зай (баттерей)” цуглуулах сав бүтээх</b></p> <p>1-р байр Д.Энхжаргал багштай 11 а анги</p> <p>2-р байр Э.Мягмардулам багштай 10 а анги</p> <p>3-р байр Т.Цогзолмаа багштай 8 а анги</p> <p>Анги хамт олноо идэвхтэй оролцуулсан багш нар:</p> <p>1-р байр 5а ангийн багш Э.Баасанжав</p> <p>2-р байр 1г ангийн багш Урандарь</p> <p>3-р байр 2г ангийн багш Батгэрэл</p>	

Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдэд зориулсан үйл ажиллагааны хүрээнд: 2023 оны 6 сарын 3-ны өдөр уурхайтай танилцах аяллыг МАК-Нарийн сухайтын уурхайтай хамтран зохион байгуулсан. Сурагчдын аяллын хүрээнд уурхайн үйл ажиллагаа болон баруун сухантын хөв цөөрмийн тохижилттой танилцав. Нийт 50 сурагч, 2 багш хамрагдсан.





**2.1.2.2023.03.25нд “Эх дэлхийн цаг” арга хэмжээг зохион байгуулсан**

2023 оны 3 сарын 27нд Дэлхийн цаг буюу +60 олон улсын дэлхийн дулаарлын эсрэг авч хэрэгжүүлдэг арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцон 20:30-21:30 минутын хооронд бүх гэрлээ унтраан оролцов.



## 2.2. Булгийн эхийг сэргээх зураг төсөл гаргах

БОМТ-нд тусгагдсаны дагуу зураг төсөл боловсруулах уст цэгийг сонгох ажлыг нутгийн малчин иргэн, Гурвантэс сумын байгаль хамгаалагч болон Бага-Овоо багийн засаг даргад танилцуулсан. Сүүлийн 3 жил хур бороо ороогүй улмаас булаг шанд ширгэсэн тул өмнө нь хашиж хамгаалсан Өврийн усны булгийг тохижуулах санал өгсөн. Үүний дагуу зураг төсөл болвсруулсан. 2024 онд зураг төслийн дагуу булаг шандын эхийг хашиж хамгаалан тохижуулах төлөвлөгөөтэй байна.



2.3. Улсын их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээг зохион байгуулахад Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран ажиллана.

2023 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажилд “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээг төлөвлөсөн. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Гоёот баг, Говь Гурвансайханы байгалийн цогцолборт газарт хамаарах Тамгатын уул орчимд иргэдийн хууль бус үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж холбогдох эзэн тодорхойгүй орхигдсон 5 га талбайд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралт “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ийн дагуу 2023 оны 1-р сарын 18-24 ний хооронд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэж өгөв. /Хүлээлгэн өгсөн акт хавсаргав/

*Эвдрэлд өртсөн газрын байдал*



*Техникийн нөхөн сэргээлт хийгдээж буй байдал*



*Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн газар*



## **5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

“Хүрэн толгой коал майнинг” ХХК нь 5459А Тусгай зөвшөөрлийн 70.47 га уурхайн эдэлбэр газар болон бусад хэлбэрийн газрыг зохих зөвшөөрлийн дагуу ашиглаж байна. Компани нь 2003 оны 03-р сараас үйл ажиллагаа явуулж ашигт малтмалын орд ашиглах 5459А дугаарын лиценз эзэмших талбайд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 4-р багийн малчин Лувсан овогтой Баярсайханы эзэмшил болох Нарийн сухайтын Шандын өвөлжөө, Хөх толгой, Хөөврийн хаваржаа орсон байна. Иймд манай компани нь МУ-ын газрын тухай хуулийн 56-р зүйлийн 2,3 иргэний хуулийн 110, 113-р зүйл Гурвантэс сумын ЗДТГ-тай харилцан тохиролцож хүлээсэн үүргийн дагуу малчин Л.Баярсайханы өвөлжөө бууцыг нүүлгэн шилжүүлж шинээр сэргээн барьж байгуулсан. 2023 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.

## **6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

“Хүрэн толгой коал майнинг” ХХК нь 2005 онд Монгол Улсын Засгийн газартай байгуулсан Тогтвортой байдлын гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт БНХАУ-ын Сэхээ-Монгол улсын Шивээхүрэн боомт Нарийн сухайтын уурхай хүртэл 56 км хатуу хучилттай зам барих тусгай зөвшөөрлийг Зам тээвэр, Аялал жуулчлалын Яамнаас авч, замын барилга байгууламжийн ажлыг эхэлжээ.

Тус хүрээлэнгийн судалгааны баг Монгол улсын “Соёлын Өвийг хамгаалах тухай” хуулийн 6-р бүлгийн 17-гийн 10-т заасны дагуу нүүрсний ордыг ашиглах төслийн хүрээнд хатуу хучилттай авто зам барих газарт 2007 оны 10-р сарын 23-наас 31ны хүртэл 7 хоногийн хугацаатай археологийн урьдчилсан хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ судалгааны ажлын хүрээнд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйлс тохиолдоогүй болно.

**Ийм учраас “Тэмээн сүргийн баяр” соёлын биет бус өвийг хамгаалах арга хэмжээг зохион байгуулдаг.**

“Хүрэн толгой коал майнинг” ХХК нь Өмнөговь аймгийн Гурван тэс сумд говийн бахархал болсон 2 бөхт тэмээн сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх, амьдын үнэлэмжийг нь дээшлүүлэх, тэмээний сүү, сүүн бүтээгдэхүүн, ноос ноосон бүтээгдэхүүний онцлог давуу талыг ард иргэдэд сурталчлах, залуу тэмээчдийг урамшуулах зорилгоор компанийн нэрэмжит “Тэмээн сүргийн баяр” –ыг 2005 оноос эхлэн тасралтгүй зохион байгуулж байгаа бөгөөд үүнд нийт 106.8 сая.төг зарцуулсан байна.

Тэмээн сүргийн баяр 2023 арга хэмжээ 14.8 сая.төг ивээн тэтгэж амжилттай зохион байгуулагдлаа.Бүдүүн тэмээний уралдаанд 18 бүдүүн тэмээ.тайлаг тэмээний уралдаанд 11 тайлаг.торомны уралдаанд 16 тором.ойрын зайд 23 тэмээ уралдав.Үржлийн ингэ буур 6. Сайхан тэмээтэй хос 5 оролцож амжилт гаргасан Малчид Уяачид Бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарыг шалгаруулж шагнаж урамшууллаа.

### "Тэмээн сүргийн баяр -2023"

"Хүрэн толгой коал майнинг" ХХК иас их говийн чимэг, цөм сүрэг болсон тэмээний тоо толгойг өсгөх, амьдын үнэлэмжийг дээшлүүлэх, ингэний сүү сүүн бүтээгдэхүүн, тэмээний ноос ноосон бүтээгдэхүүний ач холбогдлыг нийтэд таниулан сурталчлах, залуу тэмээчдийг урамшуулах зорилгоор санаачлан, ивээн тэтгэдэг тэмээний баяр 17-р жарны төмөр бар жилийн өвлийн адаг сарын шинийн 8-ны бэлэгт сайн өдөр Өмнөговь аймгийн Гурвантэс сумд 17 дахь жилдээ "Тэмээн сүргийн баяр -2023" нэртэйгээр амжилттай зохион байгуулагдлаа.



*Уралдаан, тэмцээнд оролцогчид*



*Бүтээгдэхүүн үйлдвэрлэгч*



### 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сэргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах	1.Цаг агаарын урьдчилсан мэдээлэлд тулгуурлан уурхайлалтыг хүрээлэн буй орчин болон хүн малын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатайгаар зохицуулан ажиллах	Нийт төслийн хүрээнд	-	Үйлдвэрлэлийн зардал		Үйл ажиллагааны турш	Компанийн онцгой байдлын үед ажиллах төвөвлөгөө
		2.Хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй материалын агуулахуудыг гадаргын урсцаас хамгаалах ба тэдгээрээс бохирдол зөөгдөхөөс хамгаалсан далан шуудуу засаж сэргээх	Түлш, шатах тослох материалын агуулах, засварын талбай	-			Үйл ажиллагааны турш, тогтмол хугацаагаар	БН ба дүрэм
		3.Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн нийт ажилчдад	-			Үйл ажиллагааны турш, тогтмол хугацаагаар	Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS5566:2008 MNS0640:89 MNS639:89
		4.Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	Төслийн нийт ажилчдад	-				
2.	Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сэргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл	1.Үйлдвэрлэлд гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж мөрдөх	Төслийн нийт ажилчдад	-	Үйлдвэрлэлийн зардал		Үйл ажиллагааны турш	MNS4990:2000 MNS4969:2000
		2.Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Төслийн нийт ажилчдад	-				



	ажиллагаа доголдох, зогсох	3.Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх	Төслийн нийт ажилчдад	-	Хөдөлмөр хамгааллын зардал		
		4.Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэрэгслээр хангах	Төслийн нийт ажилчдад	-			
		5. Ажилд гарахын өмнө эмчийн үзлэгт бүх ажиллагсдыг хамруулах;	Төслийн нийт ажилчдад	-			
		6.Гал унтраах багаж хэрэгслээр иж бүрэн хангах, шаардлагатай газарт байрлуулах, зориулалтын дагуу ашиглах, холбогдох хүмүүс тэдгээрийг ашиглах арга ажиллагаанд суралцсан байх;	Төслийн хэмжээнд нийт ажилчдад	-	Үйлдвэрлэлийн зардал		
3.	Нүүрсээр ажиллах халаалтын зуухан дах нүүрсний шаталт, түлшний бүтэц, уурын зуухны хэлбэр хэмжээ, шатаах нөхцөл, ачааллаас шалтгаалан үүсэх бохирдолт ЗДА-аас хэтрэх эрсдэл үүсэх	1.Шатах тослох материалын хор аюулын талаар сургалт явуулах	Уурхайн нийт ажилчид	-	Үйлдвэрлэлийн зардал	Үйл ажиллагааны турш	БН ба Дотоод журам, дүрэм
		2.Шатах тослох материалыг тусгайлан бэлдсэн саванд хадгалах	ШТМ	-			
		3.Шатах тослох материал ачиж буулгах, цэнэглэх хэсэгт асгарсан тохиолдолд хөрсөнд нэвчүүлэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	ШТМ-ын агуулах болон засварын талбай	-			
	<b>Нийт</b>				-	-	-

## 1. Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сэргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах

1.1 Цаг агаарын урьдчилсан мэдээлэлд тулгуурлан уурхайлалтыг хүрээлэн буй орчин болон хүн малын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатайгаар зохицуулан ажиллаж байна. Байгалийн аюулт үзэгдэл болсон тохиолд “Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г баримтлан ажиллах бөгөөд 2023 онд байгалийн аюулт үзэгдэл тохиолдоогүй болно.

1.2 Хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй материалын агуулахуудыг гадаргын урсцаас хамгаалах ба тэдгээрээс бохирдол зөөгдөхөөс хамгаалсан.

*Бохирдсон тос, тослох материалын хадгалалт, хөрсний хяналт*



1.3 Үйлдвэрлэл, уурхай дахь объектуудын гал унтраах анхан шатны багаж хэрэгсэлд хяналт тавьж, сар бүрийн эхний 7 хоногт тэмдэглэл хөтлөн, шалгаж байна.



1.3.1 МУ-ын Засгийн газрын 339 дүгээр тогтоолын хавсралтад заагдсаны дагуу 6 дугаар сарын 14нд Гамшгаас хамгаалах бэлэн байдлын сургалт зохион байгуулан, дуут дохио дуугаргаж (Сирень) нийт ажиллагсдын бэлэн байдлын сургалтыг зохион байгуулсан.






1.4 2023 оны 10 сарын 20-ны байдлаар үйлдвэрлэл, уурхай дахь объект, машин техникүүдэд үзлэг шалгалтуудыг хийхэд ажилчдын хотхонд (Кемп) 42 ширхэг, уурхайн объектуудад 27 ширхэг, уурхайн машин техникүүдэд 42 ширхэг, ШТС - 5, XDF 10 нөөцөд 58 ширхэг, нийт 184 ширхэг галын хор байна.



2.1. Үйлдвэрлэл уурхайн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, болзошгүй аваар ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны үзлэг шалгалт, ажлын байрны хими, физикийн хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, техникийн бэлэн байдлын үзлэг шалгалтыг улирал бүр хийж, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.



2.1.1. Техникийн үзлэг шалгалт хийсэн байдал:

№	Техник машин механизмын нэр	Дуут дохио	Гэрэлтүүлэг	Суудал	Тормоз	Кондишн	Галын хор	Бусад
1.	Бульдозер	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
2.	Түлшний машин	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
3.	Усны машин-41	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
4.	TR-104	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Тормоз гүйж барьдаг
5.	TR-107	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Тормоз гүйж барьдаг
6.	TR-110	Хэвийн	Хэвийн	Ажиллахгүй	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Тормоз гүйж барьдаг
7.	Белаз-521	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
8.	Белаз-563	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
9.	Белаз-591	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
10.	Белаз-612	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
11.	Ачигч-1200	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
12.	Сэрээт ачигч	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
13.	Ачигч-56	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
14.	Ачигч 57	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Зогссон
15.	Автогрейдер	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
16.	ЕХ-870 №09	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
17.	ЕХ-1200	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
18.	САТ793-4ш	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	
19.	САТ777-3ш	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	Хэвийн	

Эрсдэлийн үнэлгээ хийгдсэн зураг

д/д	Үйл ажиллагаа	Бодит болон боломжит аюулууд	Эрсдэл үүсэх шалтгаан	Одоо байгаа эрсдэл			Хяналт, сайжруулалтын арга хэмжээ	Хяналт, сайжруулалтын дараах эрсдэл		
				Эрсдэлийн зэрэг (ЭЗ-М*Х)				Эрсдэлийн зэрэг (ЭЗ-М*Х)		
				Маг ал ал	Хөх ир о л	Эрсдэлийн зэрэг		Маг ал ал	Хөх ир о л	Эрсдэлийн зэрэг
<b>НҮГ. БҮРЭН БУС ТЕХНИК ТЭЭВРИЙН ХЭРЭГ С.ЛЭЭР ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХ</b>										
1	Дуут дохио ажиллагаагүй бол	Мөргөлдөх, шүргэлзэх, мөргүүлэх	Дуут дохио хэвийн бус техник тээврийн хэрэгслээр ажилд гарах	А	4	23	- Ажилд гарах техник тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалыг шалгаж, дуут дохио тогтмол өгч хэвших	Д	2	3
2	Гэрэлтүүлэг хэвийн бус	Үзэгдэх орчин хягаарлагдана	Гэрэлтүүлэг муу, үзэгдэх орчин хягаарлагдмал техникийг шөнийн цагаар ажилд гаргах	Б	5	25	- Гэрэлтүүлэг муу техник, тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахгүй байх - Шөнийн цагаар гэрэлтлэг маяк захиалж үйчилгээний машинуудад байршуулах /фургон/	Г	2	5
3	Суудлын ажиллагаа хэвийн бус үед	Хөдөлмөрийн чадвар алдалт	Суудалны түрш ажиллагаагүй болсон, шууд гагнасан техникт удаан хугацаагаар ажиллах	В	4	18	- Суудал захиалах, эвдрэл гэмтэлтэй болсон суудлыг солих эвдэрсэн шалтгааныг тодруулах.	Д	1	5
4	Эйр кондишн ажиллагаагүй үед	-Ажлын хувцас хамгаалах хэрэгсэл өмсөхгүй -Хөдөлмөрийн чадвар алдалт -Ажлын бүтээмж буурна -ХАБЭА-н дүрэм журмын хэрэгжигчт хангалдахгүй	Техникуудийн үзлэг шалгалтыг тогтмол хийгээгүй. Эсвэл захиалга удаан хугацаагаар хойшилсон, эвдэрсэн шалтгааныг тодруулж арга хэмжээ аваагүйгээс болж удаан хугацаанд ажиллуулах	В	4	18	- Техникуудийн үзлэг шалгалтыг тогтмол хийж байх - Техник тээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгслийг захиалахдаа нөөцтэй захиалах ба эвдрэл гэмтэл гарах бүрд засаж, сайжруулах арга хэмжээг авч байх	Г	2	5
5	Тормозны ажиллагаа хэвийн бус үед	Осол аваарай гарах	Тормозны ажиллагаа хэвийн бус техник, тээврийн хэрэгслийн ажилд гаргах	Б	5	25	-Тормоз нь ажиллагаагүй техник тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахгүй байх -Эвдрэл гэмтлийг яаралтай засаж, сайжруулсаны дараа ажилд гаргаж байх	Д	2	3
6	Кабины хаалга, цохны шил эвдэрхий, хагархай бол	-Үзэгдэх орчин хязгаарлагдмал /шил/ -Аваарь осол, гат гарсан үед тээх боломжгүй /Хаалга/	-Захиалга удаан хугацаагаар хойшилсон -Эвдрэл гэмтэлтэй эсэхийг мэдсээр байж ажилд гаргасан	Б	3	17	- Шил цуурсан шалтгааныг илрүүлж, ажитны буруутай үйлдлээ болсон бол акт үйлдэх - Орлуулах, солих боломжгүй бол яаралтай захиалгаг өгч удирдлагад мэлгэлэх - Захиалгыг аль болох хурдан хугацаанд хүлээн авах - Захиалга иртэл ажиллуулж болох эсэхийг удирдлагаас асууж, зөвшөөрөл авсан байх	Д	2	3

2.1.2. Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт хийсэн байдал:

(Физик хүчин зүйлийн хэмжилт)



Байгуулалтын нэр: "Хүрэн толгой кокс найвч" ХХК

Бүртгэлийн дугаар: №01

(The registration number)

ХАБЭЗ, БО ХЭМЖ Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт

Хэмжилт хийсэн өгөө: 2021 он

(Date of performance)

№	Хэмжилт хийсэн цэг, ажлын байрны нэр (Location in the workplace, the name of the workplace)	MNS4990:2000	MNS4996:2000	MNS5002:2000	
		MNS4990:2015	Физикийн хүчин зүйлийн хэмжилтийн үзүүлэлт, нэмж (Measurement result of physical factor, add)		
		Агаарын температур °C	Харьцангуй чийглэг, %	Гэрэлтүүлэг, Люкс	Шуугны түвшин, ДБА
<b>Энхшээртэй дэд хэсгээ</b>		16-27	30-60	0.5*, 150-200	85
1. Өлбөрөлтийн талбайд					
1.	Өрөөний машинистын ажлын байранд KQG-150Y	21,0	34,1	86,1	Хэвийн
2.	EX-1100 маркийн жижиг операторын ажлын байранд	22,0	30	84,9	Хэвийн
3.	EX-1900 маркийн жижиг операторын ажлын байранд	20,1	33,1	81,9	Хэвийн
4.	EX-870 маркийн жижиг операторын ажлын байранд	21,0	33,4	75,2	Хэвийн
5.	SAT-385 маркийн жижиг операторын ажлын байранд	21,0	33,4	75,2	Хэвийн
6.	TEREX-100 маркийн ачаагийн машин операторын ажлын байранд	21,9	37,8	70,6	Хэвийн
7.	Ковш ачаагийн машин операторын ажлын байранд	22,0	33,0	81,0	Хэвийн
8.	Усны машины жолоочийн ажлын байранд -4)	18,9	29,5	71,6	Хэвийн
9.	Түлдний машины жолоочийн ажлын байранд	17,0	32,7	70,9	Хэвийн
10.	УАЗ Фургоны жолоочийн ажлын байранд	18,9	29,0	85,0	Хэвийн
11.	Уурын зуухны галчгийн ажлын байранд	21,9	30,8	135	Хэвийн
12.	Засварын байрны зуухны Сэвдэн				Хэвийн
2. Ажилчдын хотын /Комп/					
1.	Ажилчдын хотын талбайд	10,5	37,8	558	Хэвийн
2.	Халуун хоол хэсгийн тогоон, Утагч, багшигч нарын ажлын байранд	18,3	37,8	558	Хэвийн
3.	Уурын зуухны галчгийн ажлын байранд	19,9	30,7	35	Хэвийн

(Физикийн хүчин зүйлийн хэмжилт)

**2.1.2. 2023 оны 10 сарын 20 байдлаарх ослын бүртгэл:**

**2.1.2.1. 2023 оны 10 сарын 20 байдлаар үйлдвэрлэл, уурхайн хэмжээнд бүртгэгдсэн ослын судалгааг хүснэгт /Хүснэгт №02/-ээр үзүүлэв.**

(Ослын судалгаа)

№	ХАБЭА-н Осол, гэмтлийн бүртгэл	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
1	Анхны тусламж												
2	Эмнэлгийн тусламж												
3	Хөнгөн ажилд шилжүүлсэн												
4	Хугацаа алдсан гэмтэл												
5	Нас барсан осол												
6	Осолд дөхсөн тохиолдол	3	3			2	3	3		2			
7	Тээврийн хэрэгслийн осол												
8	Галын осол												
9	Техникийн осол												
10	МШӨ												
11	Зөрчил гаргасан ажилчид												
12	<i>Нийт (Давхацсан тоогоор)</i>				16								

**2.1.2.1** Дээрх гарсан зөрчлүүдтэй холбогдуулан үйлдвэрлэл, уурхайн нийт ажиллагсадад аюулгүй ажиллагааны ээлжит бус давтан зааварчилга, анхааруулга, санамжуудыг хүргэж, холбогдох акт, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч ажилласан.

**2.1.2.2** 2023 оны 10 сарын 20 -ны байдлаар бид бүхэн **680400 хүн/цаг** үйлдвэрийн осол авааргүй ажилласан байна.

**2.2** Үйлдвэрлэлд гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч компанийн хэмжээнд ХАБЭА-н журам, зааврыг боловсруулан холбогдох удирдлагаар батлуулан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

*1. Аюулгүй ажиллагааны журмын жагсаалт*

№	Журамын нэр	Батлагдсан огноо	Хуудасны тоо
1.	ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАРИМТ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАЛТ, БҮРТГЭЛЫН ЖУРАМ	2020.08.30	22
2.	ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТ ОРОХ, ЗААВАРЧИЛГА ӨГӨХ, ШАЛГАЛТ АВАХ ЖУРАМ	2020.08.30	10
3.	АЮУЛЫГ МЭДЭЭЛЛЭХ, ЗӨРЧЛИЙГ ИЛРҮҮЛЭХ ЖУРАМ	2020.08.30	5
4.	ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ, ХЯНАХ ЖУРАМ	2020.08.30	5
5.	ХАБЭА-Н ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ	2020.08.30	5
6.	АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС, ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН ОЛГОЛТ, АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛСАН ЖУРАМ	2020.08.30	5
7.	АЖЛЫН БАЙРНЫ ҮЗЛЭГИЙН ЖУРАМ	2020.08.30	3

8.	КОМПАНИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙД ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ГҮЙЦЭТГЭЖ БУЙ ГЭРЭЭТ КОИПАНИУДЫН МӨРДӨЖ АЖИЛЛАХ ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРАМ	2022.08.28	5
9.	ЗӨВШӨӨРЛӨӨР АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ	2020.08.30	3
10.	ҮОХХМШӨ-Н ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ	2020.08.30	9
11.	РАДИО СТАНЦ АШИГЛАХ ЖУРАМ	2022.08.28	4
12.	ЭМНЭЛЭГ, ЭРҮҮЛ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ	2022.08.28	9

## 2. Аюулгүй ажиллагааны зааврын жагсаалт

№	Зааврын нэр	ААЗ Дугаар	Хуудасны тоо	Батлагдсан огноо
1.	Нийт ажиллагсдын мөрдөх ААЗ №001	01	5	2022.08.18
2.	Компанийн цех хэсгүүдэд мөрдөх галын ААЗ №002	02	5	2022.08.18
3.	Аюул, осолд өртөгсдөд үзүүлэх анхны тусламжийн талаарх ААЗ №003	03	4	2022.08.18
4.	Үйлдвэр, уурхайн талбайгаар зорчих үеийн ААЗ № 004	04	2	2022.08.18
5.	Тэсэлгээний цооног өрөмдөх үеийн ААЗ № 005	05	5	2022.08.18
6.	Тэсэлгээ хийгдэх үеийн ААЗ № 006	06	2	2022.08.18
7.	Экскаваторын операторын ААЗ № 007	07	5	2022.08.18
8.	Автосамосвалын операторын ААЗ № 008	08	9	2022.08.18
9.	Автогрейдер, бульдозерын операторын ААЗ № 009	09	7	2022.08.18
10.	Утгуурт ачигчийн операторын ААЗ № 010	10	4	2022.08.18
11.	Зам услах машин-чийн мөрдөх ААЗ № 011	11	3	2022.08.18
12.	Засварчны мөрдөх ААЗ № 012	12	7	2022.08.18
13.	Дугуй засварчны мөрдөх ААЗ № 013	13	7	2022.08.18
14.	Машин механизм, техникүүдэд тосолгоо хийх үед мөрдөх ААЗ№014	14	5	2022.08.18
15.	Ачаа оосорлох үед мөрдөх ААЗ № 015	15	4	2022.08.18
16.	Гар ба цахилгаан багажаар ажил гүйцэтгэх үеийн ААЗ № 016	16	4	2022.08.18
17.	Цахилгааны засвар үйлчилгээ хийх үед мөрдөх ААЗ№017	17	5	2022.08.18
18.	Цахилгаан хийн гагнуурын ажил гүйцэтгэх үеийн ААЗ № 018	18	5	2022.08.18
19.	Ачааг механизмаар өргөх зөөх үеийн ААЗ № 019	19	3	2022.08.18
20.	Дизель мотор ажиллуулах үеийн ААЗ № 020	20	2	2022.08.18
21.	Гараар ачаа өргөх үеийн ААЗ № 021	21	4	2022.08.18
22.	Уурын зуух, галч ажилтны ААЗ № 022	22	2	2022.08.18
23.	Уурхайн бүсээс гадна машин техникаар ажил гүйцэтгэх үед мөрдөх ААЗ № 023	23	2	2022.08.18
24.	Үйлчилгээний машины жолоочийн мөрдөх ААЗ № 024	24	3	2022.08.18
25.	Ажлын талбарт түлш цэнэглэх үед мөрдөх ААЗ №025	25	5	2022.08.18
26.	Газар шорооны ажил гүйцэтгэх үеийн ААЗ №026	26	2	2022.08.18
27.	Ирлэх суурь машин дээр ажиллах үеийн ААЗ №027	27	3	2022.08.18
28.	Хүнс бараа материалын агуулахын мөрдөх ААЗ №028	28	2	2022.08.18
29.	Шат тавцан буюу өндөрт ажиллах үеийн ААЗ№029	29	4	2022.08.18
30.	Паяльникаар ажиллах үеийн ААЗ №030	30	2	2022.08.18
31.	Маркшейдер туслахын мөрдөх ААЗ№031	31	6	2022.08.18
32.	Ахлах тогооч, тогооч, бэлтгэгчийн ажлын байрны мөрдөх ААЗ№032	32	4	2022.08.18
33.	Үйлчлэгч, угаалгын ажилчин нарын мөрдөх ААЗ №033	33	3	2022.08.18
34.	Насосны машинчийн мөрдөх ААЗ № 034	34	4	2022.08.18
35.	Үйлдвэрлэл, уурхайн бүсэд зочдын мөрдөх заавар №035	35	2	2022.08.18
36.	Сэрээт ачигчийн операторын мөрдөх ААЗ№036	36	3	2022.08.18
37.	Онцгой дэглэм буюу Ковид-19 цар тахлын үед мөрдөх ААЗ №037	37	4	2021.12.24

MNS4969:2000 стандартын дагуу Компанийн 178, Нарийн сухайт уурхайн 108, ХХА-ны 12 – нийт ажилчдад 2023/10/20 байдлаар давхацсан тоогоор 894 ажилчдад 894 хүн/цагийн УЭДЗ -г өгч, шалгалт авч баталгаажуулсан. Өөр ажлын байранд шилжсэн 25 хүн/цаг, шинээр орсон ажилчинд урьдчилсан зааварчилгаа 82 ажилтанд 250 хүн/цаг сургалт нийт 1169 хүн/цагийн зааварчилгаа, сургалтыг зохион байгуулсан.

*Сургалтын явц*



**2.4** ХАБЭА-н тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан ЗГ-ыг тогтоол, тушаал, дүрэм, журам, стандартын дагуу ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, хор саармагжуулах бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүй олгон ажиллаж байна.

**2.5** Ажилд гарахын өмнө эмчийн үзлэгт бүх ажиллагсдыг хамруулах

Ажилд гарахын өмнө эмчийн анхан шатны үзлэгт бүх ажиллагсдыг хамруулан ажиллаж байна.





**2.6** Галын болон гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрлэл, уурхайн үйл ажиллагааны онцлогт тохирсон төлөвлөгөө боловсруулан, Гурвантэс сумын ГТУА-67 анги, ӨМА-ийн ОБЕГ, УУАА-р батлуулан ажиллаж байна.


(ГУШТ, АУХШТ, ГХТөлөвлөгөө)



**3.1** Нүүрсний шаталтаас бий болох тоос, хүхрийн оксидууд ( $SO_x$ ), азотын оксидууд ( $NO_x$ ), Зарим шатдаггүй хэсгүүд буюу нүүрстөрөгчийн оксид (CO), бусад органик нэгдлүүд нь уурын зуухны үйл ажиллагааны нөхцөлөөс хамаарах тул аль болох бага бохирдолт үүсгэх уурын зуух сонгон, ашигладаг.

Манай компани нь 178 хүн ажилладаг бөгөөд ахуйн хэрэгцээнд бага хүчин чадалтай уурын зуух ашигладаг. Уурын зуух, даралтад савнуудын /дугуйн компрессор, өрмийн компрессор 3ш/ баталгаажилтыг “Армос” ХХК-тай 2023 оны 06-р сарын 22 -ны өдөр № 0466322 дугаар гэрээг байгуулж хийлгэсэн.

**3.2** Шатах тослох материалын хор аюулын лавлах мэдээллийн агуулгаар сургалт явуулах: Үүний дагуу 2023 оны 6 болон 8 сард ХАБ,ЭА,БО-ны хамтарсан сургалт зохион байгуулсан.




Шатах тослох материал ачиж буулгах, цэнэглэх хэсгийг хатуу хучилттай болгон, алдагдаж асгарсан тохиолдолд хөрсөнд нэвчүүлэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Бохирдсон тос, тослох материалыг уурхайн тосгоны зүүн урд байрлах тос солих цэгт бэлтгэсэн 30 тонн багтаамжтай ёмкост хийж, хөрсний бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллаж байна. /хөрсний хяналт, тослох материалын хадгалалт/

*Бохирдсон тос, тослох материалын хадгалалт, хөрсний хяналт*



*Шатах тослох материалаар бохирдсон хөрс хатаах талбай*



## **8. ХОГ, ХАЯДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

### ***Хог хаягдлын нөлөөллийг бууруулах арга зам***

Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашиглах боломжтой хаягдлыг боловсруулах, дахин ашиглах боломжгүй үлдсэн хог хаягдлыг тогтоосон хугацаанд зохих журмын дагуу устгах ажлыг хэрэгжүүлж байна. Ажилчдыг холбогдох сургалтад тогтмол давтамжтайгаар бүрэн хамруулдаг. Ахуйн бохир усыг Бохир ус цэвэршүүлэх байгууламжид цэвэрлэдэг. Хог хаягдлыг зохих журмын дагуу хадгалах, устгах, булшлах үйл ажиллагаа явуулж буй “Шугшаа уул” ОНӨААТҮГ-д гэрээний дагуу нийлүүлдэг.

### ***Хог хаягдал***

Төслөөс гарах хатуу хог хаягдлын хувьд ахуйн болон үйлдвэрлэлийн гаралтай хаягдал гарах бөгөөд 120 орчим ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хог, цаас гэх зэрэг хуурай хаягдлууд хамаарна. Үйлдвэрийн гаралтай хатуу хог хаягдлын хувьд гадаад дотоод овоолгод байршуулагдах хөрсний чулуулаг, хөрс хуулалтын ажлын явцад хуулагдах балансын нөөцийн зарим хэсэг, ус цэвэрлэх цөөрөм, байгууламжийн тундас зэргээс мөн хаягдал шуудай, машин техник, тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн хаягдал болон төмөр утас зэрэг хаягдлууд хамаарна. Үүнээс мятал болон бусад дахин ашиглах боломжтой хог хаягдлыг тусгай талбайд хурааж, тээвэрлэн борлуулах арга хэмжээ авах нь зүйтэй. Уурхайн хатуу хог хаягдлаас төмөр, хөнгөн цагаан, хүхэр, натри, магни, кали, кальци, цахиур, титан болон бичил элементүүд орчныг бохирдуулж болзошгүй. Тиймээс уурхайн олборлолтын явцад уурхайн үйл ажиллагаа болон ажилчдын ахуйн хэрэглээний хатуу хог хаягдлыг дахин боловсруулж болох, эс болох төрлөөр нь ангилан дахин боловсруулж болох хаягдлыг түүхий эд авах цэгт тушааж, дахин боловсруулахгүй хогийг сумын нэгдсэн хогийн цэгт нутгийн захиргаатай гэрээ байгуулан хаях шаардлагатай. Мөн хатуу хог хаягдал түр хаях цэгийн талбайн бохирдлыг хөрсөнд нэвчихгүй байх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал.

### ***Шингэн хаягдал***

Уурхайн шингэн хаягдалд уурхайн хаягдал ус болон уурхайн ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах шингэн хаягдал зэрэг багтах бөгөөд эдгээрээс тунадас бодис, нефтийн бүтээгдэхүүнүүд, фенол, сульфат, хлорид, карбонат, гидрокарбонат, азотын нэгдлүүд, хүнд болон хөнгөн металлуудын ионууд, бактери зэрэг бохирдуулагч элементүүд үүснэ.

### ***Хийн хаягдал***

Машин механизмын хөдөлгүүрээс утаа, угаар, хөө, тортог, хорт бодис ихээр агаарт хаягддаг. Энэ нь агаар орчныг бохирдуулах, ажиллагсдын эрүүл мэнд болон ойр орчмын хөрс, ургамлын бүрхэвчид муугаар нөлөөлж болзошгүй байна. Хийн хаягдлуудаас шалтгаалан тоос, тортог, азот, нүүрстөрөгчийн ислүүд, хүхрийн давхар исэл, хүхэрлэг устөрөгч, аммиак, формальдегид, фосфорын ангидрид, хлор, бензапирен болон бусад бичил элементүүд ялгаран агаар орчинг бохирдуулж болзошгүй.

Уурхайн үйл ажиллагааны улмаас үүссэн ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг анхан шатанд нь ангилан ялгалт хийж хог хаягдлын хэмжээг багасгах, дахин ашиглагдах

хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай хадгалах, ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд уурхайн хэмжээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

- Төв оффис, Уурхайн орчны цэвэрлэгээ
- Хатуу хог хаягдлын хадгалалт, хяналт
- Ахуйн хог хаягдлын ангилан ялгалт
- Хатуу хучилтын 56км авто замын хажууг цэвэрлэх

Уурхайн болон ахуйн хэрэглээнээс үүсэж бий болсон хогыг ангилан ялгаж хогийн түр цэгт хадгалдаг. Мөн орчны цэвэрлэгээг тогтмол хийдэг бөгөөд уурхайн тосгон, ажилчдын тосгон, уурхай хүртэлх замын дагуух хог зэргийг цэвэрлэдэг.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая/төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая/төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	1.Хог хаягдлыг цуглуулахад стандартын шаардлага хангасан савыг сонгох, ажилчдын байр, оффис, агуулах зэрэг газруудад байрлуулах, засварлаж байх	Төслийн хүрээнд	ширхэг	0.2	6	1.2	2023 онд жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь
		2.Хог хаягдлын ангилан ялгалт тухай бүр хийнэ.	Төслөөс гарах хог хаягдал	-	-	-	-	2023 онд жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь
		3.Хог хаягдлыг түр хадгалах цэгүүдийн зэрэглэлээс хамааран хашлага хийх бүрэн бүтэн байдалд хяналт тавих.	Хог хаягдал түр хадгалах цэг	ширхэг	2.0	2	2.0	2023 онд жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь
		4.Хийсэж тархсан болон үүссэн хог хаягдлын овоолгыг тогтмол цэвэрлэж хэвших	Төслийн хүрээнд	удаа	-	12	-	2023 онд жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь

2.	Үйлдвэрийн	1.Хатуу хог хаягдлын хадгалалт, хяналт. Машин механизмаас (эд анги, ашиглагдсан тос, тослох материал, аккумулятор, дугуй) гэх мэт сэлбэг хэрэгсэл, дахин ашиглагдах хоёрдогч түүхий эдийг тодорхой түр цэгт төвлөрүүлэн хуримтлуулан хадгалж байгаад хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлнэ.	Төслийн хүрээнд	удаа	1.0	1	1.0	2023 онд жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь
3.	Аюултай	1.Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд түр хадгалах /шатах тослох материал/	Төслийн хүрээнд	тонн	2.0	1	2.0	2023 онд жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь
		2.Аюултай хог хаягдлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагуудтай гэрээлэн нийлүүлэх замаар эх үүсвэр дээрээс зайлуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	удаа	-	-	-	2023 онд жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь
	Нийт						<b>6.2</b>		

## 1. Ахуйн хог хаягдал

1.1 Хог хаягдлыг цуглуулахад стандартын шаардлага хангасан савыг сонгох, ажилчдын байр, оффис, агуулах зэрэг газруудад байрлуулах, засварлаж байх

Хог хаягдлыг цуглуулахад стандартын шаардлага хангасан савыг сонгох, ажилчдын байр, оффис, агуулах зэрэг газруудад байрлуулж байна.



*Хогийн сав байрлуулалт*



1.2 Хог хаягдлын ангилан ялгалт тухай бүр хийдэг.

*Ахуйн хог хаягдлын ангилан ялгалт*



*Байгаль орчны болон хог хаягдлын чиглэлээр 2 удаа нийт ажилчдад сургалт орсон*



**1.3** Хог хаягдлыг түр хадгалах цэгүүдийн зэрэглэлээс хамааран хашлага хийх бүрэн бүтэн байдалд хяналт тавих.

*Ажилчдын хотхон -хогийн цэг шинэчлэл сайжруулалт*



*Бохир ус цэвэршүүлэх байгууламж*



**1.4** Хийсэж тархсан болон үүссэн хог хаягдлын овоолгыг тогтмол цэвэрлэж хэвших

Уурхайн болон ахуйн хэрэглээнээс үүсэж бий болсон хогыг ангилан ялгаж хогийн түр цэгт хадгалдаг. Мөн орчны цэвэрлэгээг сар бүр тогтмол хийдэг бөгөөд уурхайн тосгон, ажилчдын тосгон, уурхай хүртэлх замын дагуух хог зэргийг цэвэрлэдэг.

*Ажилчдын хотхон- нийтийн цэвэрлэгээ*



*Худаг усны ойр орчим цэвэрлэгээ*





*Уурхай - нийтийн цэвэрлэгээ*



*Уурхайн дотор болон гадна талбайн цэвэрлэгээ*



*Авто зогсоолууд*



*Авто замын цэвэрлэгээ*



*Нүүрс тээврийн зам*



## 2. Үйлдвэрийн хог хаягдал

2.1 Хатуу хог хаягдлын хадгалалт, хяналт. Машин механизмаас (эд анги, ашиглагдсан тос, тослох материал, аккумулятор, дугуй) гэх мэт сэлбэг хэрэгсэл, дахин ашиглагдах хоёрдогч түүхий эдийг тодорхой түр цэгт төвлөрүүлэн хуримтлуулан хадгалж байгаад хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлнэ.

Уурхайн техникийн хогийн цэгийг цэвэрлэж, ялган ангилсан. Ангиллыг аккумулятор, шүүлтүүр, бошиг, шаланг, бусад техникийн төмөр гэж ангилан ялгаж дахин ашиглаж байна.


Өмнө



Дараа



Хаягжуулалт



## 3. Аюултай хог хаягдал

3.1 Аюултай хог хаягдлын зэрэглэлээс хамаарах хог хаягдлын цэгт хамгаалалтын хашлага татах. Хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг хангах.

Бохирдсон тос, тослох материалыг уурхайн тосгоны баруун урд байрлах тос солих цэгт бэлтгэсэн 6 тн багтаамжтай 2 ш ёмкост хийж, хөрсний бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллаж байна. /Хөрсний хяналт, тослох материалын хадгалалт/

*Бохирдсон тос, тослох материалын хадгалалт, хөрсний хяналт*



*Шатах тослох материалаар бохирдсон хөрс хатаах талбай*



**3.2** Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд түр хадгалах, эрх бүхий мэргэжлийн байгууллагуудтай гэрээлэн нийлүүлэх замаар эх үүсвэр дээрээс зайлуулах арга хэмжээг хэрэгжүүлэх

*Химийн бодисын эрсдэлийн менежмент*

Аюултай химийн бодис уурхайд ашигладаггүй “Бласт” ХХК –иар тэсэлгээний ажлыг гэрээгээр хийлгэхээр болсон бөгөөд үүссэн хог бохирдлыг бүрэн хариуцахаас гадна, технологийн дагуу өрөмдлөг тэсэлгээний ажлыг хийдэг бөгөөд уурхайн ашиглалтын явцад уурхайн хүнд машин механизмын (эд анги, ашиглагдсан тос, тослох материал, аккумулятор, дугуй) гэх мэт сэлбэг хэрэгсэл, дахин ашиглагдах хоёрдогч түүхий эдийг тодорхой цэгт төвлөрүүлэн хуримтлуулан хадгалж байгаад хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлдэг.

“Мон пити ойл” ХХК-тай хамтран ажиллах санал тавьж гэрээ байгуулан “МАК”ХХК-тай хамтарсан байдлаар хаягдал тосоо акт үйлдэн хүлээлгэн өгч байна. Аюултай хог хаягдлыг тусгай цэгт байршуулаад байна.



## 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

### *Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго зорилтууд*

“Хүрэн-Толгой” нүүрсний уурхайг ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад “Хүрэн толгой коал майнинг” ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүнийг тодорхойлох арга, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, холбогдон гарах зарим зардлуудын хамт тодорхойлж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулсан болно.

Орчны хяналт шинжилгээний нэгдсэн хөтөлбөр нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэг чухал хэсэг байдаг бөгөөд төслийн үйл ажиллагаа байгаль орчин, нутгийн иргэд, ажиллагсдын амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа эсэхийг хянах орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх удирдамж болдог.

Тус төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төсөл хэрэгжих орчны байгалийн болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, төслийн сөрөг нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөх зорилготой. Өөрийн хяналт, шинжилгээний багажаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл зэрэгт байнгын хяналт тавьж ажиллаж байна.

Байгаль орчны 5 бүрэлдэхүүн хэсэгт хийгдэх нийт 9 төрлийн хяналт шинжилгээ явуулах хэлбэрийг боловсруулан оруулав. Зардлын тооцоонд зөвхөн дээж сорьцыг авах болон түүнийг шинжлүүлэх лабораторийн шинжилгээний зардлыг тооцсон.

Орчны хяналт шинжилгээний ажлыг жил бүрийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн тайланд оруулж байгаль орчны асуудал эрхэлсэн орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана. Мөн байгууллагын дотоодын хяналтыг хэрэгжүүлэх, төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг тухай бүр хянах, цаг алдалгүй хариу арга хэмжээ авах зорилгоор байгаль орчны асуудал хариуцсан ажилтан сар болон улирал тутам хяналт шинжилгээний дүн мэдээгээр тайлан бэлтгэж, зохих удирдлагадаа тайлагнаж байна.

Хүрэн толгойн уурхайн онцлог нь энэ бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй бусад уурхайн үйл ажиллагаанаас үзүүлж буй сөрөг нөлөөлөл хуримтлагдах, хамсах нөхцөлтэй бөгөөд ялангуяа энэ нь агаар орчинд үзүүлж буй нөлөөлөл дээр тод илэрнэ. Иймээс уг бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй төсөл хэрэгжүүлэгчид байгаль хамгаалах үйл ажиллагаагаа хамтран зохион байгуулах нь илүү үр дүнтэй байх болно.

Орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэхдээ төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтан хээрийн хэмжилт дээжлэлтийг хийх ба үр дүнг тайлагнахдаа Монгол улсын холбогдох стандартад харьцуулан үзэх, мэргэжлийн байгууллага, судлаачидтай хамтран ажиллаж зөвлөгөө авах, итгэмжлэгдсэн лабораториудтай хамтран ажиллах, эрх бүхий субьектээр дүгнэлт гаргуулах хэлбэрээр ажилласан.

Мөн энэ онд “SGS” ХХК, “МАК” ХХК, ” Хүрэн толгой коал майнинг” ХХК, “Өсөх зоос” ХХК/дөрвөн уурхайн хамтарсан “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”-ийн тендерт ажлыг “Эко Тякүүн” ХХК-тай гэрээ байгуулан 2023 оны 10-р сарын 16нд хийж гүйцэтгүүлсэн.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
<b>АГААРЫН ЧАНАР</b>								
1.	Агаар дахь тоосжилтын хяналт	- Карьерын орчимд, - Овоолгын орчимд - Уурхайн тосгон	Сар бүр	12	-	-	Өөрийн тоос хэмжигч багаж	MNS 4585:2007 MNS:3384:1982 MNS:4048:1988
<b>ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХИ УС</b>								
1.	Гадаргын болон газрын доорх усны чанар: Гол ионы найрлага: анион, катион, микро элементийн агууламж, Ундны усны микробиологийн хяналт шинжилгээ	- Уурхайн худаг бүрээс /нийт-3 худаг/ - Уурхайн шүүрлийн уснаас /1 цэгээс /	Улирал тутам	4	1.125	4.5	Хэмжилзүйн лабораторитай хамтран ажилла	MNS 900:2005
2.	Ахуйн хаягдал усны хяналт шинжилгээ	Ахуйн хаягдал ус цэвэрлэх байгууламж	Жилд 1 удаа	1	0.1	0.1		-
<b>ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>								
1.	Ялзмагийн агууламж, рН, давсжилт, чийгшил, NO <sub>3</sub> -N, P <sub>2</sub> O <sub>5</sub> , K <sub>2</sub> O, рН, нийт азот, нийт фосфор,	- Нөлөөлөлд өртөөгүй талбай - Шимт хөрсний овоолго	Жилд 2 удаа	2	0.2	0.4	Хэмжилзүйн лабораторитай хамтран ажилла	MNS5850:2008

2.	Нефть, нефтийн бүтээгдэхүүн, нүүрс устөрөгчид, хүнд металлын агууламж микробиологийн үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> <li>- Хогийн цэг</li> <li>- Цэвэрлэх байгууламжийн дэргэд</li> <li>- Засвар үйлчилгээний төвийн дэргэд</li> <li>- Шимт хөрсний овоолгоос</li> </ul>	Жилд 2 удаа	2	0.2	0.4	Хэмжилзүйн лабораторитай хамтран ажилла	MNS 5850:2008
<b>АМЬТНЫ АЙМАГ</b>								
1.	Амьтны төрөл зүйл, тоо толгой, шилжилт хөдөлгөөн	Нийт тусгай зөвшөөрлийн талбайд	Жилд 1 удаа	1	8.5	8.5	“Эко Тякүүн” ХХК, 4 уурхай хамтран хэрэгжүүлэх	Батлагдсан арга зүйн дагуу
	Нийт					<b>13.9</b>		


## 1. Агаарын чанар:

2023 онд агаарын тоос хэмжигч, халаасны анемометр зэрэг багажаар сар бүр байгаль орчны хяналт шинжилгээ хийж тоосжилт ихтэй үед зам талбайн усалгааг ойртуулах зэрэг уулын ажилтай уялдуулан зохион байгуулсан.

*Агаарын тоос хэмжигч /CASELLA-cel2712*



*Халаасны анемометр /Anemometer/*



## 2. Гадаргын болон газрын доорх ус:

Уурхай орчмын газрын доорх усны хяналт шинжилгээний ажлыг “Сантгидро консалтинг” ХХК-тай гэрээ байгуулан улирал бүр хамтран ажиллаж байна. Тус хяналт шинжилгээний ажлын үр дүнд:

- Уурхайн ахилтад өртсөний улмаас уурхайн бүсэд газрын доорх усны түвшинд 2-4 метрийн бууралт үүссэн.
- Кемпийн зоогийн газрын унд ахуйд хэрэглэж буй усны эрдэсжилт бага, усны төрөл Натри-Гидрокарбонат ( $\text{Na-HCO}_3$ ) байна.
- Ашиглалтын худгийн ус Монгол улсын ундны усны стандартад нийцэж байгаа бөгөөд шүүлтүүрээс гарсан усанд гидрокарбонат болон эрдэсжилтийг эрс бууруулж байна.
- Нөлөөллийн бүсэд газрын доорх усны түвшний өөрчлөлт үүсээгүй.
- Унд ахуйд хэрэглэж буй усанд гидрокарбонатын ионы эзлэх хувь хэмжээ бага.
- Нөлөөллийн бүс, уурхайн бүсийн усны найрлага төрөл ижил буюу натри-сульфатын төрөл ( $\text{Na-SO}_4$ ).

*“Сантгидро консалтинг” ХХК усны дээж мониторинг*



*Усны түвшин хэмжигч багаж/Solinst-Water level meter/*



*Усны дээж 6 цэгээс 5 дээж авалт*



**3. Хөрсөн бүрхэвч:**

2023 онд 3 удаа хэмжилзүйн лабораторид шинжилгээнд хамруулсан. /Хариуг хавсаргав/

*Хөрсний дээж 9 цэгээс 20 дээж авалт*





### **Ахуйн хортон шавж устгал, халдваргүйтгэлийн ажил**


Халдваргүйтгэлийн ажлыг “Хүслэн Хийморь”ХХК-тай 2023 онд хийсэн гэрээний дагуу уурхайн бүсэд 3 удаа хийж гүйцэтгээд байна. Үүнд: уурхайн эмч болон тархвар судлаач, ариутгагч нар хамтран уурхайн дараах газруудад гүйцэтгэлийн ажил хийсэн.

Үүнд:

1. Ажилчдын кемп 1700 м<sup>2</sup> /шавж устгал хамт хийгдсэн/
2. ЗҮТөв 1250 м<sup>2</sup>
3. Оффис 597 м<sup>2</sup>
4. Хог хаягдлын цэг 50 м<sup>2</sup>
5. Мод тарьсан талбай 2500 м<sup>2</sup>
6. Бохир ус цэвэршүүлэх байгууламж 90 м<sup>2</sup>
7. Хоол үйлдвэрлэлийн газар 1305 м<sup>2</sup>
8. Агуулах 280 м<sup>2</sup>

Халдваргүйтгэлийг БОАЖЯ-ны сайд, ХХААХҮЯ-ны сайд, ЭМЯ-ны сайдын 2020 оны А/125, А/69, А/143 хамтарсан 2021 оны 02-р сарын23-ны өдрийн №А/52, А/42, А/71 тоот тушаалын 4-р хавсралтад тусгагдсан “Жавилеон” бодисын 0.015%-н уусмал /өрөө, тасалгаануудад/, 0.03%-н уусмал /ариун цэврийн өрөө/ тус тус бэлтгэж Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04-р сарын 20-ны өдрийн А/227 тоот тушаалын 4 дүгээр хавсралтыг баримтлан хийсэн.

Мөн үйлдвэр уурхайн ариутгал халдваргүйтгэлийн ажлыг 7 хоног бүр хуваарийн дагуу ариутгаж байна



#### 4. Амьтны аймаг

Нарийн сухайтын бүлэг ордын орчны хяналт шинжилгээг: “МАК” ХХК, “SGS” ХХК, “Өсөх Зоос” ХХК болон манай уурхай хамтран орчны хяналт шинжилгээ “Эко Тякүүн” ХХК-иар хийлгэсэн бөгөөд агаар, хөрс/ хүнд, хөнгөн металл/ ургамал, амьтан гэсэн үндсэн орчны хяналт шинжилгээг хийлгэсэн. Энэ гэрээний дагуу 9.8 сая төгрөг зарцуулсан. /Гэрээг хавсаргав/

*Агаар хяналт шинжилгээ*



*Хөрс хяналт шинжилгээ*



*Усны хяналт шинжилгээ*



*Амьтан, ургамал хяналт шинжилгээ*



## 10. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

1. Гурвантэс сум болон БОАЖЯамнаас өгсөн чиглэлийн дагуу 2020 оны 01-р сарын 31-ний өдөр Гурвантэс сумын удирдлага болон Нарийн сухайтын бүлэг ордод үйл ажиллагаа явуулж байгаа уурхайн удирдлага, байгаль орчны мэргэжилтнүүд хуралдсан. Тус хурлын шийдвэрээр.

Нарийн сухайтын бүлэг ордод үйл ажиллагаа явуулж буй уурхайнууд хамтран сумын хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулан цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын урт хугацааны төлөвлөгөө гарган төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг жил бүр хийж ажиллана.

Зураг төслийн дагуу хийх ажлын нийт зардал 495,708,965 төгрөг. 2023 онд нэг компаниас жилд 34 сая буюу нийт 136 сая.төг ажил хийж гүйцэтгэнэ.

/Нөхөн сэргээлтийн арга хэмжээний хүрээнд хийсэн/

2. Өмнөговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны дугаар 9/8 тогтоол, Өмнөговь аймгийн Засаг даргын 2019 оны А/1354 захирамжийг үндэслэн “Хог хаягдал үүсгэсний хураамж”-ийг Гурвантэс сумын ИТХ-ын 2015 оны 01 сарын 12-ны өдрийн дугаар 03 тогтоолын дагуу төлбөрийн даалгавар үүсгэн төрийн сангийн дансанд хагас, бүтэн жилээр төвлөрүүлж байна.

/ хог, хаягдлын менежментийн хүрээнд/

3. Баруун сухантын хөв цөөрөм, амралтын талбай Гурвантэс сумын засаг даргын тамгын газарт хүлээлгэн өгсөн. Цаашид тус үерийн болон гадаргын ус хуримтлуулах талбайд хяналт тавих, орчныг сайжруулах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар санал солилцсон. Үүний дагуу дараах ажлыг зохион байгуулсан.

- Баруун сухантын хөв цөөрмийн мэдээллийн самбар, эко нойл угсарч байрлуулж ногоон байгууламжийн усалгаа ачилгааг тогтмол зохион байгуулсан.

4. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 05 сарын 15 ны дугаар А/160 тушаалаар батлагдсан ажлын хэсэг Хүрэн толгой уурхайд ирж хяналт шалгалт хийсэн. Ажлын хэсгээс албан шаардлага хүлээн авч ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Үүний дагуу хийсэн ажил:

1. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах иргэн, байгууллага, аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээг “Шугшаа уул” ОНӨААТҮГ-тай байгуулж 2023.08.10нд 25м<sup>3</sup> хог хаягдлыг Гурвантэс сумын хог хаягдлын цэгт ачуулсан.
2. Уурхайн хог хаягдал ангилан ялгах хогийн савыг хаягжуулж тэмдэглэгээ хийсэн
3. ШТС-ын 3 цэгээс хөрсний дээж авч Улаанбаатар хот “Инженер геодези” ХХК-ийн хөрсний лабораторид шинжилгээд хамруулсан
4. Шатах тослох материалаар бохирдсон хөрсний хатаах талбайг /өргөн-4м, урт-10м, зузаан-8 см/ 40м<sup>2</sup> зутгаж бетондуулсан.
5. Байгаль орчинд ээлтэй стандартын шаардлага хангасан бие засах газрын судалгааг хийж 3 байрлалд эко нойл угсарч байрлуулсан.
6. Байгаль орчны нийцлийн болон гүйцэтгэлийн аудит хийлгэх “Enviromental completes” компанийг сонгон аудит хийлгэсэн.

## **11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Компанийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу уурхайн үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах, түүний биелэлтэнд хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг мэргэжлийн ажилтан, багт хариуцуулах
- Байгаль орчныг хамгаалах болон хөдөлмөр хамгаалах, аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтан нь уурхайн дээд шатны удирдлагад шууд харъяалагдаж ажиллах бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг төлөвлөж ажиллах
- Олборлолт явуулсан талбайн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай зэрэгцүүлэн хийх
- Нөхөн сэргээлтийн болон байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх бөгөөд нөхөн сэргээлт хийж дууссан талбайг орон нутгийн захиргаанд хүлээлгэж өгөх
- Уурхайн бүх ажлыг ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу явуулах, технологийн процессыг паспортжуулах
- Олборлолтын явцад археологи, палентологи, түүх, соёлын дурсгалт зүйлс илэрвэл сумын ЗДТГ, мэргэжлийн зохих байгууллагад яаралтай мэдэгдэж хамгаалах арга хэмжээ авах
- Орон нутгийн засаг захиргаа олон нийтийн байгууллага иргэдийн санал бодлыг сонсож зохих арга хэмжээ авах харилцан мэдээлэл солилцож байхаас гадна ажилчдын эрүүл мэнд байгаль орчныг хамгаалах, гэнэтийн болзошгүй осол аюулыг арилгах чиглэлээр аймгийн мэргэжлийн хяналтын газар болон сумын ЗДТГазартай нягт хамтарч ажиллах
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл газар хөдлөлт үер салхи шуурга болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг нэгээс хоёр удаа сургаж дадлагажуулах энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллах
- Уурхайн ажиллагсдын дунд байгаль хамгаалах талаар ухуулга яриа сурталчилгааны ажлыг зохион байгуулах
- Хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гал түймрийг унтраах багаж хэрэгслийг бэлтгэж байнга бэлэн байлгах
- Уурхайн ухаш усан сан болон суваг шуудуу нь хүн мал амьтан унах живж осолдохоос сэргийлсэн хаалт хашлагатай байх бөгөөд эргэн тойронд нь анхааруулах хориглох санамж тавьж ослоос сэргийлэх арга хэмжээ авах
- Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч ус хөрс агаарын бохирдол хөрсний эвдрэл элэгдэл усны нөөцийн байдалд хяналт тавьж ажиллах

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв сая.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Хэрэгжилт
			2023 он				
			Сар	Сар	Сар		
1.	Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах;	Цалингийн сангаас	Үйл ажиллагааны турш			Уурхайн удирдлага	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжлийн ажилтан томилон ажиллуулж байна. Байгаль орчны инженер П.Энхбаяр, Г. Батбаяр, Усны мэргэжилтэн 2, нийт 4хүн
2.	Байгаль орчны ажилчдыг мэргэжил дээшлүүлэх сургалт, семинарт хамруулж байх	1.2	1	4	-	Уурхайн удирдлага	1.2023.01.30нд Хариуцлагатай уул уурхай нөхөн сэргээлт, орчны хяналт шинжилгээ сургалт Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт хамрагдсан. 2.2023.04.05-07нд "Монголын алт (МАК)" ХХК-ийн байгаль орчны албанаас зохион байгуулсан “Оюу толгой”ХХК туршлага солилцох аялалд оролцсон.
3.	Уулын ажлын төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах талаар тодорхой ажлуудыг тусган түүнийг мөрдөн ажиллах	ҮЗ	Үйл ажиллагааны турш			Байгаль орчны инженер	Байгаль орчныг хамгаалах талаар шимт хөрсний овоолго, нөхөн сэргээлт, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг тусган ажиллаж байна.
4.	Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах, зохих төрийн захиргааны төв байгууллагуудад хянуулан батлуулж ажиллах	ҮЗ	10	12	1	Байгаль орчны инженер	2023 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан хийгдсэн. Зохих төрийн захиргааны байгууллагуудад хянуулан батлуулж байна.
5.	Байгаль орчны аудит хийлгэх	ҮЗ		9			2023 онд байгаль орчны аудит хийлгэсэн.
6.	Байгаль орчны менежментийн системийн үнэлгээ	-		9			“Монголын Алт МАК” ХХК-ийн “Байгаль орчин, тогтвортой хөгжлийн газар”-аас байгаль орчны менежментийн системийн үнэлгээ хийж ERP системд нэгдэн орж байгаа тул мэдээ, мэдээллийг “Байгаль орчин, тогтвортой хөгжлийн газар”-ын мэргэжилтэнд хүргүүлж хамтран ажиллаж байна.
Нийт		1.2					

**12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, Сая.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Гурвантэс сумын ЗДТГ, нутгийн иргэдэд	Уулзалт, хурал, цуглаан	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	Тухай бүрт	1.0	БОИ	Бага овоо багийн төвд
2.	Өмнөговь аймаг Байгаль орчны газар	БОМТБТайлан хүргүүлсэн		11-р сарын 01-ний дотор	-	БОИ	Төслийн талбай, уурхай
3.	БОАЖЯ-ны ХБОБНУГ-г албан бичиг	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр болон Файл хэлбэрээр		2023 оны 12-р сард	-	БОИ	Улаанбаатар хот
	Нийт				<b>1.0</b>		


**1.1** Бага-овоо багийн нутагт хэрэгжиж буй "Монгол алт"МАК ХХК, "Хүрэн толгой коал майнинг" ХХК нь "Нарийн сухайт" нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслүүдэд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд нэмэлт тодотгол, хийж байгаа "Грийнтрэндс" ХХК, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч ажилласан.



**1.2** Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй нүүрсний уурхай 2023 оны 10 сарын 26 өдөр 10 цагаас Соёлын төвд Уул уурхайн удирдлагууд болон орон нутгийн иргэд аж ахуй нэгж, сумын удирдлагууд оролцсон /Хамтын ажиллагааны гэрээнд тусгах бараа ажил үйлчилгээ, ханган нийлүүлэлтийн/ талаар хэлэлцүүлэг болсон. Уул уурхайд ханган нийлүүлэлт хийх сонирхолтой аж ахуй нэгж, иргэд оролцсон.



**1.3** 2023 оны 11 сарын 23-нд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Бага-Овоо багийн иргэдийн нийтийн хуралд уурхайн компаниуд 2023 оны Байгаль орчны тайланг танилцуулсан.



**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө  
биелэлтийн нийт зардал**

№	Төлөвлөгөөт ажлын бүрэлдэхүүн	Төлөвлөгөө /сая.төг/	Тайлан /сая.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10.6	12.1
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	40.6	47.4
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	30.0	30.2
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	5.5	14.8
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ҮЗ	ҮЗ
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	6.2	6.2
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	13.9	13.9
9	Аймаг, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	-	-
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	2.2	1.2
11	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	1.0	1.0
	<b>Дүн</b>	<b>110</b>	<b>126.8</b>
<b>Үйлдвэрлэлийн зардлаас</b>			
1	Хог хаягдал төлбөр		2.6
2	Ус ашигласны төлбөр		45.2
3	Газар ашигласны төлбөр		72.4
4	Байгаль орчны аудит		11.1
			<b>131.3</b>




## ДҮГНЭЛТ

